

# Нээлттэй Нийгэм Форум

## ЖИЛИЙН ТАЙЛАН 2008



Жамъян гүний гудамж – 5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-48, Монгол Улс

Утас: (976-11) 313207, Факс: (976-11) 324857  
Вэб сайт: <http://www.forum.mn>

# Гарчиг

ӨМНӨТГӨЛ ..... 3

Форумын үйл ажиллагааны чиглэл:

## АРДЧИЛСАН ЗАСАГЛААЛ

Чөлөөт, шударга сонгууль	8
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	12
ТТБ-үүдийн төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг	16
Иргэдийн оролцоо ба Мэдээллийн эрх чөлөө	22
Шүүхийн хараат бус байдал	24
Эрх зүйн туслаалцаа	26
Стратегийн өмгөөлөл	29

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Төсвийн мониторинг	34
Байгалийн баялгийн орлогын ил тод байдал ба менежмент	37
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	39
Бизнесийн орчин	42
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	44

## НИЙГМИЙН БОДЛОГО

Нийгмийн хамгаалал	48
Боловсролын чанар, хүртээмж	50
Хүүхэд, залуучуудын хөгжил	52

Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгсэл:

Хөгжлийн мэдээллийн төв	54
ПОРТАЛ САЙТ	56
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	59
ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	60
ХЭВЛЭН НИЙТЛЭЛ	62
ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ	64

## БУСАД ХАВСРААЛТ

Дорно Дорно хөтөлбөр	66
Санхүүгийн тайлан	71
Ажилтнууд	75
Товчилсон үгс	76





Өмнөтгөл

2008 он парламентын тав дахь удаагийн сонгуулийн жил байв.  
Энэхүү сонгууль хамгийн бүдлиантай сонгууль, эсвэл бүдлиантай болсныг хамгийн их мэдсэн сонгууль болж монголын арчиллын түүхэнд орлоо.

Сонгуулийг шударга зохион байгуулж явуулах нь урьд урьдаас илүү түвэгтэй болох нь улам бүр илэрхий болж байсан ч холбогдох төрийн байгууллагууд үүнийг гүнзгий ухамсарлан иргэдийн өгсөн санал өөрчлөгдөхгүй байх, иргэд үүнд итгэлтэй байх нөхцлийг бүрдүүлж ажиллаж чадсангүй. Улс төрийн намууд ч сонгуульд оролцохдоо улс орныхоо хувь заяны өмнө хүлээсэн хариушлагаа гүйцэд ухамсарласангүй. Хэдийгээр дэлхийн санхүүгийн хямрал аль эрт аюулын харанга дэгдээгээд, жижиг ч гэсэн хүнс, түлшний импорт болон ашигт малтмал, мал аж ахуйн бараг боловсруулаагүй түүхий бүтээгдэхүүний экспортод дулдүйдах байдлаар даяаршсан Монголын эдийн засаг, зах зээлийг тэвдүүлэх нь тодорхой болоод байсан ч сонгуулиар бэлэн мөнгө амалдаг зуршлаа давтаад зогсоогүй, харин ч олон дахин өсгөж энэ сонгуульд оролцов.

Нэг талаас, өдрөөс өдөрт дордох болсон айл өрх, иргэдийн амьжирааны түвшин, нөгөө талаас, улс төрийн оновчтой шийдэл, бодлогын дорвитой шинэчлэлт, өөрчлөлтийн их хүлээлт сонгуулийн уур амьсгалыг бүрдүүлж байлаа. Гэсэн ч сонгуулийн дүн гарахад энэ агуулга бүрдээгүй нь илэрсэн юм. Үүнд эргэлзсэн байж болох олон хүн эсэргүүслээ шууд илэрхийлж төв талбайд цугларснаар сүүлдээ эмх замбараагүй мөргөлдөөнд хүргэж, Монгол Улсад анх удаа онц байдал зарлаж, эцсийн дүндээ таван хүн амь үрэгдэж, олон арван иргэн, хууль сахиулагчид гэмтэж бэртэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хохирол үүсч, мөн л олон арван иргэн, төрийн албан хаагч хууль, шүүхийн байгууллагын хаалга сахиж, хоригдож, ялтан болоод байна. Хожим түүхэнд Долдугаар сарын 1-ний хэрэг явдал хэмээн тэмдэглэгдэх энэ үйл явцын учир шалтгаан, үр дагавар, сургамж, бодит нөхцөл байдлыг эрх зүйн орчны агуулгаар нэгтгэн сайн шинжлээгүй байгаа хэдий ч чухамхүү яаж үнэлж цэгнэж, олон залуусын хувь заяа хаашаа эргэхээс хамааран бидний Монгол Улс иргэнших түүхийнхээ хаана нь явааг илчлэх их сорилгын жилийн тооллыг эхлүүлсэн нь маргаангүй юм.

2008 он санхүү, эдийн засгийн хямралын эхлэл байв. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн уналтаас эхэлсэн давалгаа долгиолсоор “хямрал манайхыг тойрно” хэмээн амарлингүй суусан биднийг цохиж, нэн түрүүнд хөрөнгө оруулалтын салбарыг хамгийн ихээр хямрааж, уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарын хөгжлийг үндсэнд нь царцаагаад байна. Хөрөнгө оруулалтын таатай цаг мөчүүд хэдийнэ алдагдснаар хямралд шахуулсан өрөөсгөл шийдвэрүүд гарах аюултай цаг өдрүүдийг авчраад байна. Мал аж ахуйн түүхий эдийн зах зээл ч хямарч, иргэдийн мөнгөн орлого эрс буурсан нь сүүлийн үеийн судалгаа болон мэдээллээс илт мэдэгдэх болжээ. Байгаль, цаг уурын хатуухан нөхцлүүд ч нэрмээс болж байна. Мөнгөний эргэлт удааширч, үндэсний валютын ханш тогтвортгүйжснээр жижиг, дунд бизнесийн салбар сөхрөх шинжтэй болов.

Үндсэндээ өнгөрсөн 2008 он нь улс төрийн тогтвортгүйжил, мөнгө-санхүүгийн системийн хямрал, иргэний нийгмийн тэсвэр-сорилго дагуулсан харш хатуу жил байлаа.

Нээлттэй Нийгэм Форум үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу 2008 онд дийлэнхи ажлаа хэрэгжүүлж чадсан бөгөөдийм хурц үйл явдлууд өрнөсөн цаг хугацаа, нөхцөл байдал тохируулан мөн л хурдтай, оновчтой байхыг хичээсээр ирлээ. Тухайлбал, ННФ-аас санаачилан сонгуулийн үеэр иргэний нийгмийн хяналт, оролцоог хангах зорилгоор “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээг бусад ТТБ-тай хамтран байгуулж, сонгуулийн ил тод байдал, шударга, хууль ёсны зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс Сонгуулийн Ерөнхий хороотой хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж нэлээд арга хэмжээг хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өглөө. Ерөөс энэ онд Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар үндэсний хэмжээний дөрвөн сүлжээ буюу эвсэл байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрлээ. Үүнд дээрх сүлжээнээс гадна төсвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 13 иргэний нийгмийн байгууллага нэгдэн “Иргэд төсвөө хянана” сүлжээ, олборлох салбарын ил тод байдлыг хангах зорилготой 20 ТТБ-ын нэгдэл болох “Төлсөн авснаа нийтэл” эвсэл, хүний эрхийг хамгаалах зорилго бүхий 23 ТББ-ыг нэгтгэсэн “Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвсэл” орж буй юм. Ингэснээр тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагууд хүч боломжоо тарамдалгүй, асуудалд

ул сүурьтай, хариуцлагатай, нэгдмэл байр сууринаас хандах нөхцөл бүрдэж, улмаар улс орны хөгжлийн дэвшлийн төлөөх үйл хэрэгтээ илүү их амжилт олно гэдэгт бид итгэлтэй байна.

2008 онд Нээлттэй Нийгэм Форум өмнө хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрүүдээ үргэлжлүүлсний зэрэгцээ хэд хэдэн шинэ ажил эхлүүлснийг дурдах нь зүйтэй болов уу. Энэ оноос эхлэн манай ННФ шүүхийн хараат бус байдлыг бодитоор үнэлэх, баримтжуулах зорилгоор мониторинг хийх асуудалд анхаарал тавьж ажиллах болов. Түүнчлэн нийгмийн даатгалын сангүүд, ялангуяа тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн ил тод байдлын асуудлуудад дүн шинжилгээ хийх зорилгоор тодорхой судалгаануудыг эхлүүллээ. Сургуулийн насны хүүхдийн чөлөөт цагийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж туршлага хуримтуулах зорилгоор “Хүүхэд хөгжүүлэх хичээлээс гадуурх хөтөлбөр”-ийн төслийг санаачилав. 2008 онд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөртөө томоохон өөрчлөлт оруулж, “Ахлах судлаач” хөтөлбөрийг шинээр бий болгосны зэрэгцээ багаараа судалгаа хийх явдлыг хөхиүлэн дэмжих боллоо.

Энэ мэт хийж бүтээсэн, бүтээхийг оролдоно зорьж яваа үйл хэргээ Эрхэм танд толилуулж буйдаа таатай байна. Хэрэв Та Нээлттэй Нийгэм Форумаас авч хэрэгжүүлсэн, санаачилсан, санхүүжүүлсэн, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар санал сэтгэгдлээ хуваалцах аваас бид талархан хүлээн авах болно.

*Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал*

*П.Эрдэнэжаргал*

# АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ



## Чөлөөт, шударга сонгуууль

Нээлттэй Нийгэм Форумаас төрийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2008 онд явуулсан үйл ажиллагааны нэг чухал үр дүн бол сонгуулийг шударга зохион байгуулах асуудлаар олон талт хэлэлцүүлэг зохион байгуулж, тодорхой санал зөвлөмж гаргасан явдал юм. Энэхүү зөвлөмжийн зарим санал УИХ-ын сонгуулийн тухай хууль болон сонгуулийг зохион байгуулахтай холбоотой Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан журамд тусгалаа олсон юм. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг ил тод болгох тухай заалт шинээр хуулинд орсон бөгөөд 2008 оны УИХ-ын сонгуулиар анх удаа сонгогчдын нэрийн жагсаалтыг санал хураах өдрөөс гурван сарын өмнө интернэтэд байрлуулж, хуулбарыг улс төрийн нам хүчинүүдэд олгон хянах боломжоор хангасан нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангахад чиглэсэн чухал алхам болсон юм.

УИХ-ын сонгуулийн үйл явцад төрийн бус байгууллагуудын хяналт тавих, мониторинг хийх чадавхийг нэмэгдүүлэх үүднээс сонгуулийн өмнө буюу 2008 оны гуравдугаар сард “Ардчилсан сонгууль: иргэний нийгмийн оролцоо” сэдэвт олон улсын бага хурлыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Дорно Дорно хөтөлбөрийн дэмжлэгтэй зохион байгууллаа. Хот, хөдөөгийн иргэний нийгмийн байгууллагуудын 180 орчим төлөөлөгч оролцсон энэхүү хуралд гадаадын 15 орны 21 мэргэжилтэн уригдан ирж сонгуульд хяналт тавьдаг арга туршлагаасаа хуваалцсан бөгөөд Монголын төрийн бус байгууллагууд 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр хэрхэн мониторинг хийх төлөвлөгөөгөө танилцуулж, арга зүйгээ толиуулан хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Үүний үр дүнд иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн үйл явцын шинэчлэлийн талаар олон улсын мэргэжилтнүүдээс суралцаж, сайн туршлага, хүлээн





зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, судалгаанд үндэслэн асуудалд үл суурьтай, нэгдмэл байр сууринаас хандах нөхцөл бүрдсэн болно.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд 2008 оны тавдугаар сарын 14-нд Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар сонгуулийн үйл явцын ил тод байдлыг сайжруулах, иргэний нийгмийн хяналт, оролцоог хангах зорилго бүхий **“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт”** сүлжээ байгуулагдлаа. Энэхүү сүлжээнд ННФ, Глоб Интернэшнл, Сонгогчдын Боловсрол Төв, Хүний

Эрх Хөгжил төв, Филантропи Хөгжлийн Төлөө төв, Мидас зэрэг төрийн бус байгууллага нэгдсэн бөгөөд сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах талаар Сонгуулийн Ерөнхий Хороотой /СЕХ/ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан юм. Санамж бичигт дурдснаар Сонгуулийн Ерөнхий хороо нь холбогдох мэдээллээр хангах, хяналт тавих нөхцлийг бүрдүүлж ажиллахаар болсон бол “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний байгууллагууд мониторинг хийх болсон юм. Тухайлбал 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр сонгуулийн кампанит ажил, хэвлэл мэдээлэл, сонгуулийн хороодын үйл ажиллагааны ил тод байдал, сонгогчдын нэрийн жагсаалтын аудит, саналын хуудастай холбоотой үйл явц гэсэн таван чиглэлээр мониторинг хийсэн бөгөөд үр дүнг нь [www.sanal2008.mn](http://www.sanal2008.mn) вэб хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд шуурхай хүргэлээ. Түүнчлэн сонгуулийн үеэр 1977 дугаартай шууд утас ажиллуулан сонгуулийн үйл явцтай холбоотой санал, мэдээллийг иргэдээс хүлээн авч СЕХ болон хэвлэл, мэдээллийн байгууллагуудад цаг тухайд нь уламжилж байсан болно.

Иргэний нийгмийн байгууллагууд нөөц боломжоо бүрэн дайчилж, СЕХ-той байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу хүлээсэн сонгуулийн үйл явцад хөндөнгийн хяналт тавих үүргээ биелүүлсэн ч харамсалтай нь СЕХ илэрсэн зөрчил дутагдлыг засах талаар ажиллана хэмээн амласнаа хөсөрдүүлсэн юм.

УИХ-аас Сонгуулийн тухай хууль, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай болон Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар болж ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан ННФ “Сонгуулийн үйл явцын эрх зүйн асуудал” сэдэвт иргэний нийгмийн форумыг 2008 оны 12 дугаар сарын 11-нд санаачлан зохион байгууллаа. Форумаар сонгогчдын нэрийн жагсаалт, саналын хуудасны нууцлал хамгаалалт, сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явц, сонгуулийн кампанит ажил, хэвлэл, мэдээллийн үйл ажиллагааг хуулиар зохицуулсан байдлын дутагдалтай талуудыг шүүн хэлэлцэж, сонгуулийн үйл явцыг цаашид хэрхэн боловсронгуй болгож сайжруулбал зохих талаар зөвлөмж гаргасныг ННФ-ын вэб порталд байрлуулан нийтээр хэлэлцүүлж байна.

## 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр хийсэн мониторингийн зарим үр дүн

Сонгуулийг цэвэр шударга зохион байгуулах нөхцлийг хангахад сонгогчдын нэрийн жагсаалтыг баталгаатай, үнэн зөв гаргах нь туйлын чухал. 2008 оны УИХ-ын сонгуулиар жишээ болгон авч үзэхэд энэ нөхцөл тэр бүр хангагдаж чадахгүй байгаа нь тодорхой харагдлаа.

Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн Филантропи Хөгжлийн төлөө төв 2008 оны УИХ-ын сонгуулийн 22 дугаар тойргийн хэмжээнд буюу нийслэлийн Баянзүрх, Налайх дүүргийн сонгогчдын нэрийн жагсаалтад хоёроос дээш хаягаар давхардан бүртгэгдсэн байсан иргэдийн хаягаар очин нэрийн жагсаалт дахь мэдээлэл үнэн зөв эсэхийг тулган хянасан болно. Мониторингийн хүрээнд дээр дурдсан хоёр дүүргийн 30 хороонд нийт **47354** сонгогчийн бүртгэлд хаягийн тулгалт хийх ажлыг 2008 оны тавдугаар сарын 26-наас зургадугаар сарын 26-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Ийнхүү хянахад сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаяг дээрээ оршин суудаг нийт **15411**, тухайн хаяг дээр байхгүй нийт **17266** хүн байв. Эдгээр 17266 хүний бүртгэгдсэн хаяг дээрээ байхгүй байгаа шалтгааныг тодруулахад 25 нь нас барсан, 2961 хүн шилжсэн, 3222 хүн түр оршин суугч байгаад нүүсэн, 11003 хүн сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа хаяг дээр огт оршин суудаггүй болон ийм хаяг огт байдаггүй нь илэрсэн байна. Сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаяг дээрээ оршин сууж буй **15411** хүний 11 нь насанд хүрээгүй хүүхэд, 424 нь гадаадад байгаа, 575 нь өөр хаягаар сонгуульд оролцено гэж мэдэгдсэн, зургаа нь цэрэгт алба хааж байгаа, хоёр хүн хорих ангид ял эдэлж байгаа зэрэг шалтгаанаар сонгуульд оролцохгүй хүмүүс байлаа.

Мониторингийн явцад **14677** хаягийг олоогүй буюу оршин суугчтай нь холбоо барьж чадаагүй ба нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тухайн хүн тодорхой хаяг дээрээ оршин суудаг эсэх мэдээллийг баталгаажуулах боломжгүй байв.

## ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Монголын Үндэсний Радио, Телевизийг Олон Нийтийн Радио, Телевиз /ОНРТ/ болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх, хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум “МҮОНТ-ийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг” судалгааг хийлгэсэн юм. Энэхүү мониторингийг ННФ-ийн захиалгаар Монголын Хэвлэлийн Хүрээлэн нэг жилийн турш хийв. Энэ хүрээнд Олон Нийтийн Телевизийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ нэвтрүүлгийн агуулгад мониторинг хийсний зэрэгцээ орон даяар 1200 өрхийн дунд “Олон нийтийн ТВ-ийн талаарх олон нийтийн үнэлэмж”-ийг судалсан нь ихээхэн үр дүнтэй боллоо. Төслийг хэрэгжүүлэхэд Аархусын Их сургуулийн профессор Пол Эрик Нилсен, мөн сургуулийн хэвлэл мэдээлэл, олон улсын хөгжлийн судалгааны магистр Деннис Скибстед нар зөвлөгөө үзүүлэн ажилласан байна.

ННФ Лондон дахь Хэвлэл, Мэдээллийн Хэрэгслийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран Глоб Интернэшнл байгууллагын “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл, мэдээллийг дэмжих нь” төслийг үргэлжлүүлэн дэмжиж, арга зүйн туслалцаа үзүүллээ. Энэ төслийн гол зорилго нь төрийн байгууллагаас аливаа мэдээллийг чөлөөтэй, ямар нэг хориг хяналтгүйгээр олж авах олон нийтийн эрхийн төлөө кампанит ажил өрнүүлж төрийн нээлттэй байдлыг бий болгоход оршиж байгаа юм. Түүнчлэн халдлага, дайралтад өртсөн сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн байгууллагын хараат бус байдал, эрхийг хамгаалах, өөрийн зохицуулалтын механизмыг хөхижүүлэн дэмжих зорилт тавин ажиллаж байна.

Мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэж явваа сэтгүүлчид элдэв дайралтад өртөх, тэднийг эх сурвалжaa илчлэхийг шаардах, мэдээлэл өгөхөөс татгалзах, тэр байтугай биеийн эрх чөлөөнд нь халдаж эрүүл мэндийг нь хохироо зэрэг зөрчил илэрч байгаа нь Монголын сэтгүүлчдийн ажиллах нөхцөл амаргүй





байгааг илтгэж байна. Төслийн хүрээнд 21 аймагт мониторинг хийж буй бөгөөд одоогийн байдлаар нийт таван мэдээлэл ирүүлснээс дөрөв нь орон нутгийн сонгуулийн үеэрх захиалгат материалтай холбоотой мэдээлэл байснаас нэг нь одоогийн байдлаар шүүхийн шатанд байна. Тавдахь зөрчлийн талаарх мэдээлэл нь МҮОНРТ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар радио, телевизийн өмчлөлийн асуудлыг дахин хянаж үзэхээр гаргасан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр юм. Үг шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж хэвлэл, мэдээллийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад болж байгаа ажээ. Энэ мэдээллийн мөрөөр хуульч ажиллаж байна.

Түүнчлэн төслийн хүрээнд сэтгүүлчдэд ганцаарчилсан болон он-лайн хэлбэрээр эрх зүйн зөвлөгөө өгч байна. Одоогийн байдлаар хоёр сэтгүүлч электрон хэлбэрийн зөвлөгөө авсан нь хөдөлмөрийн маргаантай холбоотой асуудал байжээ.

2007 онд сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн байгууллагатай холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны судалгааг Монгол Улсын хэмжээнд хийж байна. Вэб сайт болон сар тутмын он-лайн сонин бичгийг гаргаж, E-Marketer компанийтай гэрээ байгуулан нийт 500 гаруй сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн ажилтуудад түгээж байна. “Хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт” гарын авлагыг хэвлэлд бэлтгэлээ.

2008 оны долдугаар сарын 1-нд Улаанбаатар хотод олон нийтийг хамарсан томоохон жагсаал цуглааны улмаас дөрвөн хоногийн хугацаатай “Онц байдал”-ыг Ерөнхийлөгчийн зарлигаар зарласан бөгөөд энэ үеэр МҮОНТВ-ээс бусад телевизийн үйл ажиллагааг бүрэн зогсоосон билээ. Энэ өдрүүдэд олон нийтэд мэдээлэл түгээх хамгийн хүртээмжтэй, хүчтэй хэрэгсэл нь хэвлэл, мэдээллийн

хэрэгслүүд байсан болно. Иймд Онц байдлын үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд, ялангуяа МҮОНТ хүний эрхийн асуудлыг хэрхэн тусгаж ажилласан, нөхцөл байдалд яж хандсан зэрэгт ННФ мониторинг хийлгэхээр болж Глоб Интернэйшил ТББ-д зохих дэмжлэгийг үзүүллээ. Долдугаар сарын 1-9-ны хооронд явуулсан 11 телевизийн нэвтрүүлгүүд болон өдөр тутмын дөрвөн сонины мэдээллийг нягтлан судалж үйл явдлын хронологи, мэдээллийн олон талт байдал зэрэгт дүн шинжилгээ хийсэн мониторингийн тайлан эхний байдаар бэлэн болоод байна.

“Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийг дэмжсэн эрх зүйн болон үйл ажиллагааны орчин бүрдүүлэх арга зам” судалгааны ажил хийгдэж сэтгүүлчдийн дунд хэлэлцүүлэг өрнүүллээ. Судлаач Ч. Базар эрэн сурвалжлах сэтгүүл зүйг олон нийтийн эрх ашгийн үүднээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих мониторингийн арга хэрэгсэл хэмээн тодорхойлоод энэ чухал салбарыг Монголд хөгжүүлэхийн тулд Эрүүгийн хуулийн зарим заалтыг хүчингүй болгохын зэрэгцээ редакцийн хараат бус байдал, сэтгүүлчдийн итгэл үнэмшил, ур чадварыг бэхжүүлэх шаардлагатай байгааг бодлогын судалгааны тайландаа дүгнэжээ. Түүнчлэн судлаач бусад орны туршлагыг судалсны үндсэн дээр сэтгүүлчдийн өөсрдийн үүсгэл санаачилгад түшиглэсэн хараат бус бүтэц бий болгож, хөндлөнгийн санхүүжилт, бие даасан бодлого бий болгохыг санал болгожээ.

## **ТББ-уудын төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг**

Ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэхэд үйлсэд иргэний нийгмийн оролцоо нэн чухал үүрэгтэй билээ. Иймээс иргэний нийгмийн гол бүрэлдэхүүн хэсэг болох төрийн бус байгууллагуудын урт хугацаанд тогтвортой оршин тогтох, төрд хяналт тавих үүргээ идэвхитэй, үр дүнтэй гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэхийг Нээлттэй Нийгэм Форум чухалчилж үздэг. 2008 онд ННФ төрийн бус байгууллагуудын дотоод засаглалыг бэхжүүлэх, тэдгээрийн төрд хяналт тавих үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр ихээхэн ажлыг төлөвлөж чамгүй үр дүнтэй ажилласан байна.

ТББ-уудын өөрийн дотоод засаглал төгс боловсронгуй байх нь эрх ашгийг нь төлөөлж буй иргэд болон доноруудын дэмжлэгийг авах, итгэлцэлд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах, цаашлаад тогтвортой хөгжихэд нь чухал үр нөлөөтэй байдаг тул ННФ ТББ-уудад зориулан “Төрийн бус байгууллагын удирдахуйн гарын авлага” номыг эрхлэн гаргалаа. Энэхүү гарын авлагад тулгуурлан дотоод засаглалын ойлголтыг улам бэхжүүлэх, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд дөхөм болгох зорилгоор “ТББ-ын дотоод засаглал, санхүүгийн хариуцлагатай менежмент” сэдэвт сургалтыг 2008 оны тавдугаар сард зохион байгууллаа. Сургалтыг АНУ-ын DePaul-ын Их Сургуулийн профессор Эллен Бенжамин, ННФ-ын санхүү хариуцсан захирал Д. Жавхлан нар удирдан явуулсан ба хот, хөдөөгийн нийт 40 байгууллагын гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүн, санхүүгийн ажилтнууд оролцож, ТББ-ын удирдлагын зохистой бүтэц, гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагын хуваарилалт, санхүүгийн удирдлага, зохион байгуулалтын талаар мэдлэг, мэдээлэл олж авлаа. ННФ өөрийн арав гаруй жилийн хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан ТББ-ууд санхүүгийн менежментээ хэрхэн ил тод, хариуцлагатай, үр дүнтэй явуулах талаар энгийн ойлгомжтой, хуулбарлан авч хэрэгжүүлэхэд дөхөм хэлбэрээр танилцуулсан нь оролцогчдын анхаарлыг баагүй татаж байлаа.

ТББ-уудын дунд явуулсан судалгааны дүнгээс харахад янз бүрийн чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй болон явуулах хүсэл эрмэлзэлтэй шинэ тутам байгуулгасан ТББ-уудын хувьд удирдах зөвлөл болоод гүйшэтгэх захирлын чиг үүргийг тусгаарласан байгууллагын дүрэм журам, шийдвэр гаргах болон хариуцлага тооцох бүтэц байгаа боловч эрхэм зорилгодоо тулгуурлан



урт болон дунд хугацааны стратеги боловсруулах, стратегийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаанд санхүүгээ ил тод, шударга хариуцлагатай хөтлөх, төсөв хөрөнгөө үр дүнтэй зарцуулах менежментийн талаарх мэдлэг сүл байна. Энэхүү хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор 2009-2010 онд ННФ-аас ТББ-уудад зориулан санхүүгийн менежментийн цуврал сургалт явуулахаар агуулга хатөлбөрийг нь тусгайлан боловсруулж байна.

1990-ээд оноос эхлэн саяхныг хүртэл ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл, нийгэмд хүлээсэн үүрэг нь үйлчилгээ үзүүлэх, соён гэгээрүүлэхэд голлон чиглэж ирсэн бөгөөд ардчилсан тогтолцоонад иргэний нийгмийн гүйцэтгэвэл зохих үндсэн үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих тал дээр санаачилга оролцоо харьцангуй бага байсаар ирлээ. Иймээс ННФ төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт тавих чиг үүргийг нэмэгдүүлэх, чадавхийг нь бэхжүүлэх зорилгоор 2005 оноос эхлэн мониторингийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Гурван жилийн хугацаанд ННФ-ын мониторингийн хөтөлбөрт нийт 90 гаруй ТББ хамрагдан, мониторинг хийх арга зүйд суралсан төрийн үйлчилгээ, бодлогын хэрэгжилт, гадаадын зээл тусlamж гэх мэт чиглэлээр богино хугацааны мониторингийн төсөл хэрэгжүүлэн практик туршлага олж авчээ. Нэн ялангуяа хүний эрх, уул уурхай, байгаль орчин, нийгмийн халамж, төсөв зэрэг салбарт төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилт, иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд хяналт тавих ТББ-ууд сүлжээ болон нэгдэж, үйл ажиллагаагаа илүү далайцтай, мэргэжлийн төвшинд явуулах нааштай хандлага гарч байна.

2008 онд ННФ-ын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрт хот болон хөдөө орон нутгийн нийт 15 байгууллага шалгарч төсөл хэрэгжүүлсэн ба мониторингийн үр дүнд илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулахад чиглэсэн үйл ажиллагааг эхлүүллээ. 2008 онд хэрэгжсэн төслүүдийг дурдвал: Дархан-Уул аймгийн Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөл орон нутгийн төрийн байгууллагын мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдалд, Филантропи Хөгжлийн Төлөө төв эд хөрөнгө, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн үйлчилгээнд, Хүний Эрх Хөгжил төв ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох төрийн үйлчилгээнд, Зориг сан Засгийн газраас иргэдэд сургалтын тэтгэлэг, зээл олгох үйл ажиллагаанд, Монголын Хувийн Мал Эмнэлгийн Холбоо төрөөс мал эмнэлгийн эм бэлдмэлийн зарцуулалтад зориулж олгодог төсвийн зарцуулалтад, Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Холбоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд, Нийгмийн Халамж Хамтын Ажиллагаа сан Дэлхийн Банкны тогтвортой амьжиргаа хөтөлбөрийн хэрэгжилтэд, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг эхчүүдийн Холбоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах үйл явц, боловсролын шинэ хуулийн хэрэгжилтэд, Говь-Алтай аймгийн Нийгмийн Дэвшил, Эмэгтэйчүүд Хөдөлгөөний салбар зөвлөл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх явцад хүний эрхийг хэрхэн хангаж буйд, Сайн Үйлс ТББ орон нутгийн амьжиргааг дэмжих зөвлөлүүдийн үйл ажиллагаа, нийгмийн халамжийн хүртээмжийн байдалд, Авилгатай Тэмцэх Сэтгүүлчдийн Холбоо Авиалын эсрэг хуулийн долдугаар зүйл заалтын хэрэгжилтэд, Хөгжлийн Саначилга Бодлого Судалын төв эмнэлгийн мэргэжлийн лиценз олгох үйлчилгээнд, Мидас ТББ төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн хүртээмжийн байдалд тус тус мониторинг хийсэн байна.

## Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын мониторинг

Хүний Эрх Хөгжил төвөөс Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газрын харьяа Геологи, уул уурхайн кадастрын газар /ГҮҮКГ/-аас ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад мониторинг хийх ажлыг 2007 оны 11 дүгээр сараас 2008 оны дөрөвдүгээр сарын хооронд хийж гүйцэтгэв.

Чингэхдээ уул уурхайтай холбоотой зөрчил ихээр гардаг байгаль орчин, орон нутгийн оролцооны асуудалд голлон анхаарал хандуулсан юм. Мониторингийн үр дүнд Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, тусгай зөвшөөрөл олгох үйл явцад зөрчил, дутагдал багагүй байгаа нь илэрлээ. Тухайлбал, холбогдох хуулиар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг журамлан зохицуулсан, түүнчлэн ГҮҮКГ-аас энэ зөвшөөрлийг олгохтой холбогдсон зарим дотоод журам, заавруудыг гаргасан байгаа ч уг хууль, журам, заавраа түүштэй дагаж мөрдөхгүй байна. АМТХ-ийн 18, 25 дугаар зүйлүүд буюу тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах, түүнийг шийдвэрлэх журмын хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргагч нь байгаль орчны үүргээ биелүүлсэн эсэх, ордын тогтоогдсон нөөц нь экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлзэх эсэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн ордын сонгон шалгаруулалт, хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоход аймгийн Засаг дарга, орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс санал авсан эсэх зэрэг асуудлыг тодорхойлсон баримтуудын бүрдэлд дээрх зөрчлүүд нэлээд илэрч байна.

Хөтөлбөрийн хүрээнд ННФ-ын зүгээс үламжлал ёсоор оролцогч ТББ-уудад зориулсан мониторингийн арга зүйн цуврал сургалт хийж, төсөл хэрэгжүүлэх явцад нь байнгын зөвлөгөө, арга зүйн туслацаа үзүүлсэн ба ТББ-уудын өөр хоорондоо туршлага солилцох, хамтран ажиллах бололцоог ханган дэмжихийн сацуу нөлөөллийн үйл ажиллагаанд нь нэмэлт дэмжлэг үзүүлэх, тайланг хэвлэн нийтэд хүртээл болгох гэх мэт үйл ажиллагаа явууллаа.

Мониторингийн хөтөлбөрт хөдөө орон нутгаас оролцох ТББ-уудын тоог нэмэгдүүлэх зорилгоор хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудад мониторингийн ач холбогдлыг ойлгуулах, арга зүйн талаар анхан шатны мэдлэг олгох сургалтыг Өмнөговь, Ховд аймгуудад зохион байгуулсан ба эдгээр аймгаас мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрт оролцох байгууллагын тоо нэмэгдлээ. Түүнчлэн Мерси Кор байгууллагын “Сургалт, нөлөөлөл, хамтын ажиллагааны сүлжээ” төслийн захиалгаар тус төслийн зорилtotт аймгуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 35 хүнд зориулан “Мониторинг” сургалтыг 2008 оны есдүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан болно.

ННФ мониторингийн талаар нэгэнт тодорхой ойлголттой болж, арга зүйн талаар мэдлэг туршлага эзэмшсэн байгууллагуудыг тодорхой салбар чиглэлд мэргэжлийн түвшинд мониторинг хийхэд нь дэмжлэг үзүүлэх, олон улсын сайн туршлага, стандарт хэм хэмжээний талаар мэдээлэл авах, туршлага солилцох бололцоогоор хангахад цаашид анхаарлаа хандуулан ажиллахаар төлөвлөж байна.

## Төрийн байгууллагуудаас иргэдэд электрон хэлбэрээр хүргэж буй мэдээллийн чанар, хүртээмж

Төрийн байгууллагууд иргэдэд мэдээлэл хүргэхдээ интернэт ашиглах нь хямд төсөр бөгөөд хамгийн хурдан шуурхай арга юм. Гэвч нэгэнт хөрөнгө хүч зарж бүтээсэн вэб сайтуудын мэдээллийн агуулгын байнгын шинэчлэл иргэдийн хэрэгцээг хангаж чадаж буй эсэхэд МИДАС ТББ 2007 оны 10 дугаар сарын 1-нээс 2008 оны тавдугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд яам, агентлагууд, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын төв, зарим сүм, Улаанбаатар хотын төв болон алслагдсан дүүргүүдийн төрийн захиргааны байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Мониторингоос харахад төрийн байгууллагуудын вэб сайтын ихэнх нь танилцуулга хэлбэрийн мэдээлэлтэй, олон нийтийг хэрэгцээт мэдээллээр хангадаггүй, түүнчлэн өөр өөр бүтээлтэй тул мэдээлэл олж авахад цаг их зарах, татвар, гаалийн зарим хэрэглээнээс өөр электрон хэлбэрээр төрийн үйлчилгээ явуулах механизм бүрдээгүй болох нь тодорхой байна. Төрийн байгууллагуудын нэгдсэн вэб сайтыг хүмүүс тэр бүр мэддэггүй, домэйн нэр нь англи хэл дээр бичигддэг нь вэб сайтын нэрийг олоход хялбар биш, мэдээлэл олж авах боломжгүй болгож байна.

Иймд төрийн байгууллагууд вэб сайтуудаараа дамжуулан иргэдэл өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээгээ хүргэх механизмыг байнгын хэрэглээ болгон хэвшүүлэх, иргэдтэй харьцах, санаа бодлыг нь сонсох хэрэгсэл болгох; вэб сайтаа өдөр тутмын хэрэглээ болгохын тулд төрийн албан хаагч болгоны ажил үүргийн хуваарь эсвэл үр дүнгийн гэрээнд өөрийн хариуссан ажлынхаа талаарх мэдээллийн шинэчлэн вэб сайт дээрээ дамжлагагүйгээр өөрсдөө оруулдаг болгох; дурын хэрэглэгч вэб сайт руу хандаад мэдээллээ олж авахад амархан болгох зорилгоор нэгдсэн вэбийн бүтцийн стандартыг мөрдөх; янз бүрийн маягт бөглөдөг системүүдийг хялбаршуулж online-aap бөглүүлэх; төрийн нэгдсэн (портал) сайтыг хүмүүст хүрэхэд хялбар болгохын тулд эх хэл дээрээ вэб сайтын нэрээ авч сурталчлах, байгууллагынхаа хаяган дээрээ вэб сайтынхаа хаягийг хамт бичих зэрэг зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргсэн байна.

# Иргэдийн оролцоо ба Мэдээллийн эрх чөлөө

Төрийн байгууллагын, нэн ялангуяа хууль тогтоох үйл явцын ил тод байдал нь олон хүчин зүйлээс бүрдсэн нэн чухал асуудлын нэг тул Нээлттэй Нийгэм Форум тодорхой үйл ажиллагаа явуулсаар ирлээ. Үүний нэг нь хууль боловсруулах, батлах явцад иргэдийн оролцоог хангах явдал бөгөөд энэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл дээр ННФ-аас тодорхой санал зөвлөмж гарган шинээр байгуулагдсан УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлэн хамтран ажиллаж байна.

2008 онд ННФ Дэлхийн Банкны хүсэлтээр хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцох боломж, хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлох судалгааг хийлээ.

## Судалгааны үр дүнгээс

Хууль тогтоох үйл явцыг зохицуулж буй эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийхэд хууль санаачлах, боловсруулах, батлах шатанд олон нийтийн санал, бие даасан судалгааны үрдүнгүстгэх арга механизмууд институцилгээдээлж байна. Иргэд хууль санаачлах, боловсронгуй болгох тухай саналаа УИХ-ын гишүүнд бичгээр хүргэж болох ч эргэх холбоо байхгүй байна. УИХ-ын гишүүн иргэд, сонгогчдоос ирсэн мэдээллийг “үнээслэлтэй” гэж үзвэл ажилдаа тусгаж болохоос гадна ер нь хууль боловсруулах ажлын явц, хуулийн төсөл зэргийг өөрсдөө хүсэх юм бол олон нийтэд мэдээлж болох ажээ. Улмаар хууль тогтоох үйл явцад олон нийтийг оролцуулах эсэх нь УИХ-ийн гишүүний сайн дүрын хэрэг болж байна. Иргэдээс УИХ-ын гишүүдэд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж хууль тогтоох үйл ажиллагаанд ашиглах арга механизмыг өнөө хэр алга байна. Судалгааны хүрээнд фокус бүлгийн цуврал хэлэлцүүлгээр засаглалын хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлох оролдлого хийлээ. Нийгмийн зүтгэлтэн, улс төрч, хуульч, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн төлөөлөгчдийн үзэж байгаагаар хуулиуд нь хэт ерөнхий зарчмуудыг тунхагласан шинжтэй тул хэрэгжилтийн түвшинд зохицуулалтын болон процедурын удирдамж болж чаддаггүй, бодлого боловсруулах үйл явцыг дэмжих хараат бус судалгаа шинжилгээ дутагдалтай, төрийн алба хэт улстөржсөн зэрэг нь Монголд өнөөдөр илэрч байгаа засаглалын ноцтой бэрхшээлүүдийг бий болгож буй бөгөөд даамжирвал засаглалын хямралд хүргэж мэдэх юм.

ННФ-ын дэмжлэгээр Мэдээлэл, Харилцаа, Холбоо, Технологийн газар, Эстонийн “Цахим Академи” ТББ-тай хамтран “Цахим засаглал ба Олон нийтийн оролцоо” сэдэвтэй сургалт семинарыг 2008 оны дөрөвдүгээр сард зохион байгуулав. Энэ сургалтад яам, агентлагийн ажилтан, хувийн болон төрийн бус салбарын төлөөлөгч, эрдэмтэн судлаач 50 гаруй хүн оролцож, төрийн байгууллагуудын вэб хуудсыг олон нийттэй харилцах механизм болгож ашиглах, иргэний бүртгэл мэдээллийг цахим хэлбэрт оруулан нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг тодорхой асуудлаар туршлага судлахын зэрэгцээ сонгуулийн цахим санал хураалт, цахим иргэний үнэмлэх зэрэг шинэлэг санаануудыг Монголд хэрэгжүүлэх боломжийг хэлэлцсэн байна.

Иргэдийн оролцооны асуудлуудаар хувь судлаачдын чадавхийг бэхжүүлэх үүднээс “Төрөөс хяналт шалгалтын чиг үүргээ гүйцэтгэхэд нь иргэд, төрийн бус байгууллагууд оролцох боломж” сэдэвт судалгааг хийж гүйцэтгэхэд нь ННФ 2008 онд бодлогын судлаач Н.Мягмарцоожид арга зүйн болоод санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Аудит, мэргэжлийн хяналт зэрэг хяналтын чиг үүрэгтэй бүтцүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн баримт бичгүүд, дөрвөн аймгаас цуглуулсан анхдагч мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн судлаач Н.Мягмарцоож төрийн байгууллагуудаас иргэдэд мэдээлэл өгөх нэг чигийн урсгал нэмэгдэж байгаа ч иргэдээс мэдээлэл хүлээж авах, шийдвэр гаргахдаа зөвлөлдөх, оролцуулах боломжууд ашиглагдахгүй байгааг тогтоож бодлогын зөвлөмж боловсруулсан байна. Иргэдийн идэвхтэй оролцоог хангах арга механизмыг холбогдох хуулиудад хэрхэн тусгах талаар тодорхой шийдлүүдийг санал болгожээ.

Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн мэдээлэл авах эрх баталгаажаагүй хэвээр байна. Олон жил яригдсан Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл 2008 онд УИХ-д өргөн баригдсан ч эхний хэлэлцүүлгээс хэтэрсэнгүй. ННФ энэхүү хуулийн төслийг улам боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэхэд анхаарч, шаардлагатай судалгаа хийх, хэлэлцүүлэг явуулах зэргээр ажиллаж байна.

## Шүүхийн хараат бус байдал


Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид шүүхийн хараат бус бие даасан байдлыг баталгаажуулсан байдаг ч олон нийтийн зүгээс шүүхэд үл итгэх явдал улам бүр нэмэгдсээр байна. Шүүх нь олон нийтийн төсөөллийн судалгаагаар хамгийн их нөлөөнд автсан байгууллагаар сүүлийн хэдэн жил тасралтгүй тодорч буй юм. Энэхүү нийтлэг төсөөлөлд тулгуурлан Нээлттэй Нийгэм Форум 2008 оноос эхлэн шүүхийн хараат бус байдлыг бодитоор үнэлэх, баримтжуулах зорилгоор мониторинг, ажиглалт хийх асуудалд анхаарал тавьж ажиллаж байна.

Шүүхийн хараат бус байдлын талаар суурь мэдээлэл цуглуулах, шүүхийн шинэтгэлийн явцад үнэлгээ өгөх ажлыг ННФ Аризонагийн Их Сургуулийн хуулийн профессор Брент Уайтын тусламжтайгаар хийж тайлан гаргалаа. Хууль, эрх зүйн салбарын нэр бүхий хүмүүсийн хүрээнд яриллага, санал асуулгын хэлбэрээр явуулсан уг судалгааны дунд шүүхийн шинэтгэлийг бүлэглэн задлан шинжилснээр доорх дүгнэлт гарсан болно.

Үүнд:

- Хараат бус байдал – хангалтгүй
- Үнэнч шударга байдал – түн хангалтгүй
- Шүүгчийн ёс зүйн дүрэм – хангалтгүй
- Хариуцлагатай байдал – хангалтгүй
- Ил тод байдал – түн хангалтгүй





Мөн суурь судалгааны нэг хэсэг болгож Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Шүүх засаглалын хараат бус, шударга байдал” сэдвээр томоохон судалгаа хийхээр болж 2008 онд судлаач шалгаруулахаар зарлалаа.

Эдгээр бодлогын судалгаа шинжилгээний ажлын зэрэгцээ олон улсын шүүхийн мониторингийн туршлагыг судалж, олон улсын зөвлөхийн тусlamжтайгаар мониторингийн арга зүй боловсруулах ажлын суурь тавигдаад байна. Польшийн Хельсинки Хороотой холбоо тогтоон тэдний олон улсад, тэр дундаа хуучин социалист орнуудад хийгдэж байсан шүүхийн мониторингийн төслүүдийг судалж байна. 2009 онд мониторингийн арга зүйгэцэслэн боловсруулж туршилтын журмаар мониторинг хийх бөгөөд үр дүнг нь нэгтгэн бодлогын зөвлөмж боловсруулан гаргах юм.

## Эрх зүйн туслалцаа

Нээлттэй Нийгэм Форумын 2004 оноос эхлэн санаачилан хэрэгжүүлсэн төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөр Засгийн газраас тодорхой дэмжлэг хүлээн үндэсний хэмжээний тогтолцоо боллоо. 2008 оны байдлаар төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх нийт 30 төв 21 аймаг, нийслэлийн есөн дүүрэгт байгуулагдан Хууль Зүй Дотоод Хөргийн Яамны зохион байгуулалт дор НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Эрх зүйн хүртээмж төсөл, ННФ-ын санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулж байна. ННФ тус төвүүдэд ажиллахаар сонгогдон шалгарсан өмгөөлөгчдийг дангаараа цалинжуулж байсан бол 2009 оны улсын төсөвт өмгөөлөгчдийн цалингийн төсвийг оруулж баталсан нь иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоо бүрдэж буйн нэг илрэл юм.

Түүнчлэн ННФ-аас ХЗДХЯ-тай хамтран хэвлүүлсэн “Эрх зүйн хөтөч” номыг иргэдийн дунд эрэлт хэрэгцээтэй байгааг харгалзан шинэчлэн найруулж хоёрдахь удаагаа хэвлүүлж, хөдөө орон нутагт, ялангуяа сүмдад түлхүү тараалаа. Хот суурин газрын иргэдийн хувьд электрон хэлбэрээр буюу “e-hutuch.mn” вэб хуудсаар эрх зүйн зөвлөгөө тусламж хүртэх боломтой болов.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг цаашид хэрхэн үргэлжлүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор ННФ 2008 онд Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Эрх зүйн Санаачилга хөтөлбөртэй хамтран уг хөтөлбөрийн хэрэгжилт, ялангуяа Эрх зүйн төвүүд болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлыг эхлүүллээ.

2008 оны УИХ-ын сонгуулийн дараахан буюу Долдугаар сарын 1-нднийтийг хамарсан эмх замбараагүй байдлын улмаас Онц байдал зарласан нь Монгол Улсад хүний эрх аль хэр баталгаатай байгааг харуулсан томоохон сорилт болсон юм. Монголын түүхнээ урьд өмнө тохиож байгаагүй энэ үйл явдлыг Нээлттэй Нийгэм Форум анхааралтай ажиглаж хүний эрхийг хамгаалах



зорилго бүхий иргэний нийгмийн 23 байгууллагатай хамтран бий болсон нөхцөл байдалд бие даасан хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт хийсний үндсэн дээр “Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвсэл” байгууллаа. Энэхүү эвслээс гаргасан мэдэгдэл нь арчилал, хүний эрхийг хамгаалахад олон нийтийн санаа бодлыг хандуулахад чиглэж байлаа. Түүнчлэн онц байдлын үеэр болон түүний дараа баривчлагдсан хүмүүсийн хүний эрхийн зөрчилд мониторинг хийж, тэдгээр иргэдэд өмгөөлөл, эрх зүйн яаралтай туслацаа үзүүллээ. Онц байдлын үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүний эрхийн талаар мэдээлсэн байдалд мөн мониторинг хийв.

Долдугаар сарын 1-ний үймээний улмаас 700 гаруй иргэн баривчлагдан хоригдож, 250 гаруй иргэн эрүүгийн хэрэгт холбогдон шүүгдэж гурван сараас долоон жил хүртэлх хугацааны ял эдлэхээр болоод байна. Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвсэл нь албадан saatuuлагдах үеэс буюу долдугаар сарын 3-наас эхлэн хүний эрхийн зөрчлийг баримтжуулах ажиллагаа эхлүүлсэн бөгөөд хүний эрхийн хэд хэдэн ноцтой зөрчлийг илрүүлэн,



баримтжуулсан тайланг 2008 оны 11 дүгээр сард төр, засгийн удирдлагууд, хуулийн байгууллагууд, иргэний нийгмийн болон судалгааны байгууллагуудад хүргэлээ. Баримтжуулалтын тайлан нь хүний эрхийн зөрчлүүдийг арилгахад нэмэлт түлхэц өгсөн болно.

2008 оны 11 дүгээр сарын 21-нд ННФ, Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвслийн хамт албадан saatулах, баривчлах үеэр хийсэн баримтжуулалтын тайлан, мөрдөн байцаах болон анхан шатны шүүхээр шүүн таслах үйл ажиллагаанд оролцох үеэр хийсэн ажиглалтын дүнг хуулийн салбарын шинжээч эрдэмтдийн хүрээнд хэлэлцүүлэв. Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвслийн өмгөөлөгчдийн баг Монгол Улсад хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд цаашид бүх шатны шүүхэд иргэдийн эрх ашгийг хамгаалж ажиллахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь нэг талаас шүүх засаглалын хэр шударга, хараат бусаар ажиллаж байгааг харуулах бодит болох юм. Түүнчлэн тус эвслээс санаачилан “Хүний эрхийн хамгаалал – яаралтай тусlamжийн сан”-г үүсгэн байгууллаа.

ННФ-ын Гүйцэтгэх захирал болон Эрх зүйн хөтөлбөр хариуцсан менежер нар 2008 оны долдугаар сарын 31-нд АНУ-ын Конгрессийн Хельсинкийн Хорооны хуралдаанд Монголын иргэний нийгмийг төлөөлөн Долдугаар сарын 1-ний үйл явдлын талаар мэдээлэл хийсэн нь олон улсын төвшинд Монголд үүссэн нөхцөл байдал, хүний эрхийн зөрчлийн талаар бодитой мэдээлэл өгөх, үйл явдлыг аливаа улс төрийн нөлөөнөөс ангид, өөр өнцгөөс харах боломжийг бүрдүүлсэн юм.



## Стратегийн омгоолол

Стратегийн өмгөөлөл нь нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шүүхэд нэхэмжлэн гаргах замаар хуулийн хэрэгжилтийг хангах, улмаар хүний эрх, эрх чөлөөг өмгөөлөн хамгаалах талаар дэлхий нийтэд өргөн хэрэглэгдэг арга хэрэгсэл юм. Монголын хувьд харьцангуй шинэ ойлголт бөгөөд стратегийн өмгөөллийг нэвтрүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2007 оноос эхлэн арга зүйн цуврал сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулан ТББ-үүд болон өмгөөлөгчдийн хүртээл болгох, иргэний нийгмийн байгууллагуудын стратегийн өмгөөлөл хийх төсөлд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Тухайлбал, уул уурхайн бүсэд амьдарч байгаа иргэдийн зөрчигдсөн эрхийг шүүхээр нэхэмжлэн стратегийн өмгөөлөл хийх зорилгоор Хүний Эрх - Хөгжил төвд ННФ дэмжлэг үзүүллээ. Төслийн үр дүнүдэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас иргэдийн эрх ашиг зөрчигдсөн 10 хэргийг шүүх, хуулийн байгууллагад нэхэмжилсэн бөгөөд 2008 оны дөрөвдүгээр сарын байдлаар эдгээр хэргийн хоёр нь шүүхэд, тав нь шүүхийн өмнөх буюу захиргааны шатанд, хоёр нь шүүхийн дараах шатанд, нэг нь хэрэг бүртгэлийн шатанд явж байна. Төслийн явцад байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлалыг яаралтай батлуулах шаардлагыг Байгаль Орчны Яаманд тавьж, олон улсын хэм хэмжээний талаарх холбогдох судалгаа тайлангийн хамт илгээнээр уг аргачлал батлагдсан нь чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Түүнчлэн ННФ 2008 онд Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн газрыг хуульбусаар олгосон таванхэргийг сонгон шүүхэд нэхэмжлэл гаргаж стратегийн өмгөөлөл явуулахад нь Үндэсний Соёмбо Хөдөлгөөнд дахин дэмжлэг үзүүллээ. Энэхүү төсөл нь 2007 онд ННФ-ын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн газарт барилга баруулах зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу олгосон эсэхэд хяналт тавих, газар олголтын асуудлаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг нээлттэй, ил тод байлгах механизмийг бүрдүүлэхэд түлхэц өгөх зорилготой юм. Төслийн хүрээнд хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, сургуулийн биеийн тамирын талбайд газар олгосон зөрчлүүдийг

авч үзсэн ба нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын 124 сургууль байдгаас 40 хувь нь биеийн тамирын талбайгаа алдажээ. Хүүхдийн тоглоомын нийт 95 талбайн 26 нь газрын маргаантай байгааг илрүүлж хууль зөрчсөн хэргүүдийг баримтжуулан, зөрчил гарах болсон учир шалтгааныг судлан дүн шинжилгээ хийсэн байна. Түүнчлэн Үндэсний Соёмбо Хөдөлгөөн 2008 онд Баянгол, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн талбайг хууль бусаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх эрх олгосон байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулахаар зохих шатны шүүхэд хандан өмгөөллийн үйл ажиллагаа явуулж эхлээд байна.



- Тоглоомын талбайг устгахаас өмнөх үеийн байдал



- Тоглоомын талбайг устгасан байдал

Чингэлтэй дүүргийн нэгдүгээр хороо, 40 мянгатын 15-р байрны “Түшиг 15” Сууц Өмчлөгчдийн Холбооны хүүхдийн тоглоомын талбайд 2001 онд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд 324 тоот захирамж гаргаж Монголын Архитекторчдын эвлэлийн kontорыг бариулах гэж байсныг оршин суугчид эсэргүүцэн зогсоосон байна. Гэтэл 2004 оны 10 дугаар сарын 6 –ны өдрийн 455 тоот захирамжаар “Ойрд импекс” ХХК болон “Түшээт” ХХК-д уг талбайд дахин барилга барих ажиллагааг түр зогссон боловч 2006 оны есдүгээр сарын 23-24-нд шилжих шөнө “Ойрд импекс” ХХК –ны ажилчид дайран орж хүүхдийн тоглоомууд, өндөр настны чийрэгжүүлэх төхөөрөмж, ургаж гүйцсэн дөрвөн ширхэг хар мод зэргийг тайран авч явсан байна.  
/ Харьцуулсан зургаар харуулав /





# Эдийн Засгийн Бодлого

---

## ТӨСВИЙН МОНИТОРИНГ

Нээлттэй Нийгэм Форумаас 2008 онд төрийн байгууллагуудын төсвийг ил тод болгох, төсөвт тавих иргэдийн хяналтыг бэхжүүлэх чиглэлээр өмнө нь хийж байсан ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэлээ. Тухайлбал, төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын үйл явцад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, дүн шинжилгээ хийх чадавхийг нэмэгдүүлэх, төсвийн иж бүрэн тоо, мэдээллийг олон нийтэд илүү өргөн хүрээнд хүргэх, төсвийн тодорхой хөтөлбөрийн хүрээнд мониторинг хийх зэрэгт түлхүү анхаарсан байна.

Төсвийн асуудлаарх иргэний нийгмийн үйл ажиллагааг тодорхой хэмжээнд сонирхож, хэрэгжүүлж байсан 13 төрийн бус байгууллага 2008 онд нэгдэн **“Иргэд төсвөө хянана”** нэртэй сүлжээг байгуулан ажиллахаар болж есдүгээр сарын 4-нд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг сүлжээ нь төсвийн тухай мэдээллийг нээлттэй, ил тод болгох, төсвийн үйл явцад идэвхтэй оролцох, төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих чиглэлээр ажиллах бөгөөд сүлжээний зохицуулагчаар эхний удаа Нээлттэй Нийгэм Форум ажиллаж байна.

Сүлжээний хүрээнд хийгдсэн эхний ажил бол иргэний нийгэм болон олон нийтэд зориулсан төсвийн тухай иж бүрэн мэдээлэл бүхий бол [www.tusuv.mn](http://www.tusuv.mn) вэб хуудас юм. Энэхүү вэб хуудсанд төсвийн хууль тогтоомж, тоон мэдээлэл, төлөвлөгөө, тайлан зэрэг эх сурвалж материал тавигдсанаас гадна иргэний нийгмийн байгууллагуудын Монгол болон бусад улсад хэрэгжүүлж байгаа төслүүд, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн гарын авлага, арга зүйн мэдээлэл орсон ба иргэд санал бодлоо илэрхийлэх бүрэн бололцоотой байх юм. Түүнчлэн Улаанбаатар хотын бүх дүүрэг, Өвөрхангай аймгийн төсвийг хэлэлцэн батлах үйл явцад 2008 оны 12 дугаар сард мониторинг хийлээ. Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын төсөв хэлэлцэн батлах хуралдаанд сүлжээний гишүүн байгууллагууд ажиглагчийн байр сууринаас оролцож, төсөвтэй холбоотой мэдээлэл цуглуулсан ба мониторингийн дүнг олон нийтэд 2009 оны эхний улиралд багтаан танилцуулж, цаашдын чиглэлүүдийг тодорхойлох юм.

Нээлттэй Нийгэм Форумын тэтгэлгээр 2008 онд хэд хэдэн төрийн бус байгууллага төсвийн ил тод байдлыг хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий жижиг төслүүдийг хэрэгжүүлээ. Тухайлбал, Орон Нутгийн Удирдлагын Хөгжлийн Сан Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануурт “Шилэн түрийвч” нэرتэй аянг дүүргийн захирагатай хамтран өрнүүлэв. Уг аяны хүрээнд төсвийн ихэнх байгууллагууд төсвийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, төсвийн хэмжээ, төсвийн зарцуулалт зэрэгт холбогдох иж бүрэн мэдээллийг сонирхогч иргэдэд хүргэхэд нь төслийн багийнхан арга зүйн дэмжлэг үзүүлсэн ба төрийн байгууллагууд, иргэдийн оролцоотой хэд хэдэн хэлэлцүүлгийг явуулсан юм. Энэ бүхний үр дүнэд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах, ил тод байдлыг хангахад чиглэсэн журам гаргасан нь чухал алхам боллоо. Түүнчлэн “Шилэн түрүүвч” төслийг бусад орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна. Тус нийгэмлэгийн түнш цэцэрлэгүүдийн захирал, багш нартай уулзалт хийж, Багануур дүүргийн туршлага, төсвийн зарцуулалтын судалгааны арга зүйг танилцуулан, төсвийн ил тод байдлын асуудлаар хэлэлцүүлэг хийлээ. Улмаар цэцэрлэгүүдийн удирдлага 2009 оны төсвөө эцэг эх, орон нутгийн иргэдэд тайлбарлах анхны уулзалтаа тухайн орон нутагтаа хийж, цаашид боловсролын төсвийн ил тод байдлыг дэмжих сүлжээ болж ажиллахаар тогтсон бөгөөд ННФ төсвийн дүн шинжилгээний чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай сургалт, гарын авлагаар хангах үүрэг хүлээлээ.

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр Дархан хотын Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжил Сан ТББ хотын орон нутгийн хөгжлийн санд мониторинг хийж, иргэдийн оролцоотой цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь тус сангийн тухай мэдээллийг иргэдэд хүргэх, санг ашиглахтай холбоотой санал, шүүмжийг аймгийн удирдлагуудад дамжуулах хоёр талтай арга хэмжээ болсон байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах чадавхийг бэхжүүлэх талаар Нээлттэй Нийгэм Форум 2008 онд нэлээд ажил төлөвлөн хэрэгжүүлэв. Тухайлбал мониторингийн төслийн хүрээнд долоон төслийг шалгаруулан эхлүүлэв. Олон Улсын Төсвийн Төсөл байгууллагаас эрхлэн гаргасан төсвийн зарцуулалтад мониторинг хийх тухай гарын авлагыг Монгол хэлнээ хөрвүүлж хэвлэлээ. Өмнөх онуудад төсвийн мониторинг хийсэн байгууллагуудыг бусад төрийн бус байгууллагад танилцуулан туршлага солицох уулзалт зохион байгууллаа. “Иргэд төсвөө хянана” сүлжээний байгууллагуудад зориулан “Төсвийн тухай ойлголт, хяналт тавих боломж” сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багшийн удирдлага дор явуулав. Орон Нутгийн Засаг Захиргааны Санаачилга байгууллагаас Украина улсад зохион байгуулсан “Төсвийн зарцуулалтад орон нутгийн аудитын байгууллагын гүйцэтгэх үүрэг” сэдэвт олон улсын туршлага солицох сургалтад төрийн бус байгууллагуудыг оролцууллаа. Түүнчлэн төсвийн чиглэлээр мониторинг хийхэд анхаарах зүйлсийн талаарх богино хэмжээний сургалтыг хоёр удаа зохион байгуулав.

Энэ бүх системтэй үйл ажиллагааны үр дүнд иргэд шийдвэр гаргах шатанд орон нутгийн болон төв Засгийн газартай хамтран ажиллах төдийгүй төсвийн мэдээлэл, ойлголтыг иргэдэд өгснөөр төрийн байгууллагууд тэдний өмнө хариуцлага хүлээгээд зогсохгүй бодлогоо хэрэгжүүлэхдээ иргэдийн ойлголцол, дэмжлэгийг авах бүрэн боломж байгааг харуулсан гэж үзэж байна.

Түүнчлэн ННФ Монгол Улсын боловсролын салбарын төсвийн үйл явцад гарч буй өөрчлөлт шинэчлэлийг нягтлан тоймлох ажлыг ЮНЕСКО-гийн хүсэлтээр хийж гүйцэтгэлээ. Боловсролын салбар нь Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр дунд хугацааны буюу “гурван жилийн шилжих зарлагын хүрээ” хэмээх аргачлалд шилжиж байгаа юм. Тойм судалгааны явцад дээрх аргачлал нь тус салбарын стратеги, төлөвлөгөөг төсвийн хуваарилалт, улс орны макро-эдийн засгийн чадавхитай нийцүүлэн уялдуулах боломжийг олгож байгаа давуу талтай хэдий ч төлөвлөх, төсөвлөх, зарлагыг хянах үүрэгтэй яам, агентлагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байгааг илрүүлсэн байна.

## Байгалийн баялгийн орлогын ил тод байдал ба менежмент

Улс орны эдийн засгийн нэг үндсэн тулгуур болох уул уурхайн салбарын ээрэг үр нөлөө нь тэр бүр жирийн иргэдэд мэдрэгдэхгүй, харин ч эсрэгээр байгалийн доройтол гэх мэт сөрөг үр дагаврууд нь орон нутгийн иргэдийн амьдралд илэрхий нөлөөлж буйн улмаас Монголын нийгэмд уул уурхайн ач холбогдолын талаар талцсан, туйлширсан байр суурь давамгайлж байна. Тиймээс тус салбарын удирдлагыг сайжруулах үүднээс Нээлттэй Нийгэм Форум 2008 онд ил тод байдлыг хангах, удирдлагыг бэхжүүлэх асуудалд түлхүү анхаарч ажилласан юм.

Юуны өмнө Монгол Улсын албан ёсоор нэгдэн орсон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын анхны тайлан 2008 онд гарсан нь Нээлттэй Нийгэм Форумын өмнөх жилүүдийн ажлын нэг үр дүн байлаа. Анхны тайлангаар уул уурхайн компаниудын улсад төлсөн гэх, мөн Засгийн газрын компаниудаас авсан гэх дүн мэдээ 96 тэрбум төгрөгөөр зөрсөн нь нийгмийн анхаарлыг татсан юм. Үг тайлан гарсантай холбогдуулан “Төлсөн авснаа нийтэл” эвсэлтэй хамтран иргэний нийгмийн байр суурийг илэрхийлсэн дүн шинжилгээ хийж, гол дүгнэлтүүдээ хэвлэлийн бага хурал зохион байгуулан танилцууллаа. Тайлангийн дүнгээр гарсан татвар, төлбөрийн зөрүүг цааш нь судлан, учир шалтгааныг олон нийтэд тайлбарлалаа. Түүнчлэн уг санаачилгын хоёрдугаар тайланг яаралтай гаргах ажлыг бусад иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулж байна.



Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг олон нийтэд ил тод болгох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум “Лиценз ажиглагч” хэмээх мэдээллийн тоймыг хоёр сар тутамд бэлтгэж, тусгай зөвшөөрлийн тухай статистик мэдээг олон нийтэд хүргэж байна. Ингэснээр лицензийн тоонд гарч буй өөрчлөлт, газар зүйн тархалт, хөрөнгө оруулагчийн тухай мэдээллийг иргэд ажиглах боломжтой болов.

Орон нутгийн түвшинд уул уурхайн орлого, лиценз олголт, гэрээний ил тод байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулахад нь иргэний нийгмийн хэд хэдэн байгууллагад дэмжлэг үзүүллээ. Тухайлбал, Хөвсгөл Далайн Эзэд ТББ, Онөөдрийн Баянхонгор сонин зэрэг байгууллага аймагтаа олгогдсон лиценз, компаниудын санхүүтэй холбоотой мэдээллийг олон нийтэд ил болгох төсөл хэрэгжүүлсэн бол Хонгор Нутгийн Дуудлага, Хил Хязгааргүй Алхам зэрэг ТББ орон нутгийн түвшинд уул уурхайн салбарын ил тод байдлыг хангахад учирч буй хүндрэл бэрхшээл, салбарын орон нутагт үзүүлж буй үр нөлөөний талаар олон талын оролцоот хэлэлцүүлэг зохион байгуулав. Уул уурхайн компаниудын ил тод байдлыг үнэлсэн “Ил тод уул уурхай” төслийг Ил Тод Байдал Сан хэрэгжүүлж байна. Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр “Төлсөн авснаа нийтэл” эвслээс ОҮИТБС-ыг сурталчлах бүсийн цуврал уулзалтыг санаачилгын Ажлын албатай хамтран Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад зохион байгууллаа.

Хамтран ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх үүднээс Орлогын Ажиглагч хүрээлэнгээс гаргасан “Гүн өрөмдөж үзэхүй” гарын авлага, Пол Коллиерийн “Адагт үлдсэн тэрбум”, Жаред Даймондын “Сүйрэл” зэрэг номыг орчуулан хэвлэлд бэлтгэлээ.

Түүнчлэн бүс нутгийн болон олон улсын түвшинд олборлох салбарын ил тод байдлыг дэмжих ажилд Нээлттэй Нийгэм Форум болон “Төлсөн авснаа нийтэл” эвслэл идэвхтэй оролцож ирлээ. “Төлснөө нийтэл” олон улсын эвслийн Стратегийн зөвлөх бүлэгт Нээлттэй Нийгэм Форумын төлөөлөгч идэвхтэй оролцон ажилласнаас гадна Төв Ази, Кавказын бүсийн иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд эвслийн төлөөлөгчид Украина улсын Одесса хотод болсон уулзалтад оролцож туршлага солилцлоо.

Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар болон уул уурхайн салбарын бодлогын бусад асуудлаар Орлогын Ажиглагч хүрээлэнтэй хамтран бодлогын дүн шинжилгээ бэлтгэж олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэлээ. Тухайлбал, уул уурхайн салбарт төрөөс хувь эзэмших хэлбэрээр оролцох, бүтээгдэхүүн хуваах зарчмаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах зэрэг асуудлаар хийсэн дүн шинжилгээ олон нийтийн анхаарлыг татсан, чухал үр дүнтэй ажил болсон юм.



## Эдийн засгийн хөгжлийн дүн шинэжилгээ

Нээлттэй Нийгэм Форум 2005 оноос эхлэн төрийн бодлого, институциуд хувь хүний арилжаа солилцоо, бизнесийн өрсөлдөөнд оролцох эрх чөлөөг аль хэр хангаж, хувийн өмчийг төгс хэмжээнд хамгаалж чадаж байгаа эсэх зэрэг зах зээлийн эдийн засгийн хөгжлийн үндсэн нөхцлийг судалдаг эдийн засгийн эрх чөлөөний асуудалд анхаарлаа хандуулан тодорхой ажлуудыг хийж байна. Энэ ажлын хүрээнд ННФ-аас санаачилан 2006 онд Монгол Улс анх удаагаа Фрейзер интитуттээс (ФИ) гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекст (ДЭЗЭЧИ) хамрагдсан юм. Түншлэгч байгууллагын хувьд ННФ нь тоон мэдээллээр хангах, тус улсын талаар тооцоолсон индексийг шалгах зэргээр хамтран ажилладаг. Монгол дахь эдийн засгийн эрх чөлөөг хэмжих чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих, эдийн засгийн эрх чөлөөний гол асуудлуудад бодлого боловсруулагчид, олон нийтийн анхаарлыг хандуулах нь энэ ажлын гол зорилго юм. Энэ үүднээс ННФ Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуультай хамтран “Монголын эдийн засгийн эрх чөлөөний тойм”-(МЭЗЭЧТ)-г тухайн жилд тулгарч байгаа эдийн засгийн шийдвэрлэх асуудлаар боловсруулан гаргаж байна.

2008 оны “Монголын эдийн засгийн эрх чөлөөний жилийн тойм” судалгаагаар “Эдийн засаг дахь төрийн оролцоо” сэдвийг сонгон судаллаа. Төсвийн орлого ихээхэн өссөн байдлыг харгалзан төсвийн зарлага, хөрөнгө оруулалтыг зөв зүйтэй тодорхойлох, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, нийгмийн хalamжийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлага улам хурцаар тавигдаж байгаа үед эдийн засаг дахь төрийн оролцоо, үүргийг эргэж харах, судлах, зах зээлийн эдийн засагт төрийн зохицуулалтын оновчтой үүргийг тодорхойлох, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, цаашид төрийн оролцоог төгөлдөржүүлэх шаардлага тулгарч байна. 2008 оны Эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгааны гол зорилго нь Монголын эдийн засаг дахь төрийн оролцоог олон улсын стандарт, туршлага, түүхэн хөгжлийн зүгээс авч үзэх, харьцуулах, зохистой оролцооны хэлбэрийг тодорхойлоход оршиж байна. Мөн төсвийн орлого, зарлага, төрийн үйлчилгээ болон түүний үр өгөөж, мөнгөний бодлого болон санхүүгийн салбарын зохицуулалтын анализ хийхийн зэрэгцээ төрийн өмчийн үйлдвэр болон бусад сонгогдсон салбарууд дахь төрийн оролцоог шинжилж дүгнэсэн болно.

Төрийн оролцоо өөрөө том сэдэв учраас нэг тоймд багтаах нь нэн хэцүү ч уншигч тус тоймоос зах зээлийн эдийн засаг дахь төрийн оролцооны онол, зарчим, практик, түүхэн хөгжил, өөрийн орны онцлог зэргийг дэлхийн бусад орны туршлагатай харьцуулах, эрдэмтэн судлаачдын дүгнэлт зөвлөмжтэй танилцах боломжтой боллоо.

Уламжлал ёсоор 2008 оны тоймын үр дүн, санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид, компаниудын тэргүүнүүд, Засгийн газрын холбогдох албан тушаалтууд, судлаачдад танилцуулан хэлэлцүүлж тэдний санаа бодол, санал шүүмжийг тоймын эцсийн хувилбарт тусгалаа. Энэ төрлийн уулзалт ярилцлага болон судалгааны хэвлэмэл хувилбар нь эдийн засгийн эрх чөлөөнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, гол асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулахад тус дөхөм болж байгаа бөгөөд цаашдаа Монголын эдийн засгийн бодлогын талаар илүү өргөн хүрээтэй мэтгэлшээн өрнөхөд хүргэнэ гэж ННФ үздэг юм.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд хэд хэдэн судалгааны ажил хийгдэж олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүллээ. Шинээр байгуулагдсан хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны тухай хууль”-д өөрчлөлт оруулна гэсэнтэй холбогдуулан энэхүү хууль, үйл ажиллагааны бодит байдалд дүн шинжилгээ хийж, хуулинд оруулах өөрчлөлтөд санал оруулах, бодлогын хувилбар боловсруулах ажлыг хийж эхлээд дуусах шатандаа ороод байна. Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчны шинжилгээний хүрээнд 2000 болон 2005 онд батлагдсан хуулиуд болон 2007 оны нэмэлт өөрчлөлтийн харьцуулалт, худалдан авах ажиллагаа болон авилгатай холбоотой эрх зүйн актуудын жагсаалт, шинжилгээг нарийвчлан судалсан болно. Худалдан авах тогтолцооны өнөөгийн бүтцийн чиг үүрэг, нэгжүүд, бодлогын орчныг шинжилсний зэрэгцээ хэд хэдэн нийтлэл, өгүүллийг нөлөөллийн үйл ажиллагаа болгон өдөр тутмын сонинд хэвлүүллээ.

Түүнчлэн бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлого” судалгааг хийв. Судалгааны гол дүгнэлт нь манай улсад инфляци нь макро эдийн засгийн мөчлөгийн өсөлттэй давхисан бөгөөд инфляцитай тэмцэхийн түлд эдийн засгийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн цогц бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн болно. Эдийн засгийн бүтцийг байгаль орчин болон гаднын зах зээлээс аль болох хараат бус болгон өөрчлөхөд чиглэсэн урт хугацааны бодлогын хувилбар хэрэгтэй байна.

## Бизнесийн орчин

Шилжилтийн эдийн засаг бүхий, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн багатай орнуудын дотроос Монгол Улс нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг тавих талаараа багагүй ахиц дэвшил гаргасаар байгаа билээ. Ардчилсан шилжилтийн үе дуусах шатандаа орж, хамгийн хүнд хэцүү ажил үлдсэн энэ үед манай улс дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөх чадавхия хөгжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Ингэснээр аль болох нээлттэй, ардчилсан нийгэм бий болгох эдийн засгийн үндэс суурийг бэхжүүлэх бөгөөд тогтвортой, өргөн хүрээтэй, тэгш шударга, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн үндэсүүдийг тавих юм.

Дэлхийн Эдийн Засгийн Форум /ДЭЗФ/ - аас эрхлэн явуулдаг эдийн засгийн өрсөлдөх чадвар ба өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийн олон улсын харьцуулсан судалгаанд манай улс 2008 онд гурав дахь удаагаа хамрагдлаа. Нээлттэй Нийгэм Форум ДЭЗФ-тай байгуулсан гэрээний дагуу Дэлхий дахини өрсөлдөх чадварын тайланд оруулах Монгол Улсын судалгааг хариуцан, Хүман Фортис Консалтанси компанийтай хамтран гүйцэтгэлээ. Энэ жилийн судалгаанд Монголд үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засаг, бизнесийн гол салбарууд, том, дунд компаниудын төлөөллийг агуулсан 308 компанийг түүвэр болгон авсан бөгөөд үүнээс 81 аж ахуйн нэгж санал асуулгад оролцлоо.

Удирдах ажилтны санаа бодлын судалгаа буюу “Бизнесийн салбарынхны дүү хоолой” тайлан судалгаагаар олоход түвэгтэй олон төрлийн хувьсагч бүхий үнэтэй өгөгдөл, мэдээллийг цуглуулсан бөгөөд 2008 оны тайланд нийт 134 улсаас Монгол Улс 100 дугаар байрт бичигдсэн нь өмнөх жилийнхтэй харьцуулахад нэг байраар урагшилсан үзүүлэлт юм. Манай хөрш хоёр орон

болов Хятад, Орос улс нь Монголоос дээгүүр буюу 30, 51 дугаар байрыг тус тус эзэлсэн байна (дэлгэрэнгүй мэдээллийг [www.gcr.weforum.org](http://www.gcr.weforum.org) хаягаар үзэх бололцоотой). “Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2008-2009”-ийн улс орон бүрт холбогдох мэдээлэлд танилцуулснаар Монголын тэргүүлэх бизнесийн удирдлагууд “бизнес эрхлэхэд хамгийн бэрхшээлтэй хүчин зүйл”-д дараахь шалтгаануудыг тооцжээ. Үүнд төр, засгийн хүнд суртал, авилга, ажиллах хүчний боловсрол, бодлогын тогтвортгуй байдал, үндэсний ажиллах хүчний сүл ёс зүй, санхүүжилт олж авах боломж, инфляци зэргийг дурдсан байна.

Хэрэгжиж болохуйц тодорхой санал боловсруулан байнгын хяналт тавьж ажиллах тал дээр хувийн хэвшил, Засгийн газар хоёрын хамтын ажиллагаа нь улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд нэн тустай. Энэхүү түншлэлд гарах ололт амжилтыг үнэлж дүгнэхэд Монгол Улсын өрсөлдөх чадварын индекст эзэлсэн жил бүрийн зэрэглэл, түүний өөрчлөлтийг нэг гол үзүүлэлт болгон ашигладаг. Өөрөөр хэлбэл, энэхүү индекст Монголын цаашид эзлэх байр суурь нь ололт амжилтыг хэмжих гадаад хэмжүүр буюу эдгээр хүчин чармайлтын үр дүнг үнэлэх “онооны талбар” болж өгдөг юм. Гэвч хувийн хэвшлийн зохион байгуулалттай, үр дүнтэй нөлөөллийн асуудал өнөөдөр манай улсад дөнгөж бүрэлдэн тогтох шатандаа явж байна. Томоохон компаниуд хувийн хэлхээ холбоогоороо дамжуулан төр, засгийн байгууллагуудаар асуудлаа шийдвэрлүүлэх хандлагатай байгаа нь жижиг, дунд хэмжээний аж ахуйн газрын хувьд тэр бүр тохиодоггүй хяслан байсаар байна.

## Орон нутгийн эдийн засгийн хөгжил

Нээлттэй Нийгэм Форум “Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх ДЕЛТА” төслийг 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд оролцож буй дөрвөн сумын стратегийн хүрээнд боловсруулсан төслүүдээс тухайн сумын иргэдийн амьдралд туйлын ач холбогдолтой зургаан төслийг 2008 онд шалгаруулж “Хөрөнгө оруулалтын сан”-гаас санхүүжүүллээ. Мөн ДЕЛТА төслийн талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулах, сонгогдсон сумдын эдийн засгийн хөгжлийн явцыг мэдээлж байх үүднээс ДЕЛТА вэб сайтыг 2008 онд ажиллуулж эхлээд байна. Вэб сайтыг шинэчлэх ажлыг хариуцсан орон нутгийн захиргаа, бизнесийн хөгжлийн албаны ажилтнуудад зориулан веб сайтыг хэрхэн шинэчлэх талаар сургалт хийлээ.

Санхүүгийн төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум 2008 оны 12 дугаар сарын 20-нд Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хууль Зүйн Үндэсний Төвтэй хамтран **“Хариушлагатай төр: Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёс”** үндэсний форумыг зохион байгуулав. Форумд УИХ-ын гишүүд, ЗГХЭГ, аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар, нийслэл, дүүргийн удирдлага, иргэний нийгмийн болон сургалт, эрдэм, шинжилгээний байгууллагуудын төлөөөлөл оролцон тодорхой сэдвээр илтгэл тавьлаа. Форумаар төрийн санхүү, төсвийн төвлөрөл, төр засгаас барьж буй бодлого, хийх ажлын чиглэл, төрийн захиргааны шинэчлэл, олон улсын туршлага, орон нутгийн ардчилал, нутгийн өөрөө удирдах ёс, орон нутгийн төсвийн орлого ба зарлагын хуваарилалт зэрэг асуудлуудыг хөндөн хэлэлцэв. Форумын үр дүнд оролцогчдоос төвлөрлийг сааруулах, төв ба орон нутгийн засаглалын харилцааг цаашид шинэчлэх чиглэлээр тодорхой зөвлөмж боловсруулан төр, засгийн байгууллагад илгээж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн болно.



Тэрчлэн Бүсийн Хөгжлийн Санаачилга ТББ-тай хамтран “Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалт” судалгааны ажлыг эхлүүлэв. Гол зорилго нь төвлөрлийг сааруулах бодлого болон түүнийг төсвийн арга замаар хэрхэн хангаж байгааг задлан шинжилж үнэлгээ өгөх явдал юм. Үнэлгээнд үндэслэн цаашид орон нутаг өөрөө захиран зарцуулах боломжтой төсвийн тогтвортой орлогыг бий болгох бодлогын хувилбарууд дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг санал болгохоор ажиллаж байна. Үүний тулд “Одоогийн төсөв санхүүгийн тогтолцоо нь орон нутагт хангалттай, урьдчилан тодорхойлох боломжтой, бие даасан, шударга тэгш байж чадаж байна уу?” гэсэн бодлогын асуултад хариулт өгөх зорилтыг тавьсан. Судалгааны ажил 2008 оны 10 дугаар сараас эхлэн хийгдэж байна. Өнгөрсөн хугацаанд судалгааны баг 2006-2008 оны



орон нутгийн төсвийн орлогын мэдээлэл дүн шинжилгээ хийж, орон нутгийн татварын орлого тус бүрийн төсөвтгүйцэтгэх үүрэг, тэдгээрийн өсөлт, бууралтад дүгнэлт хийж, аймаг, сумдын татвар тус бүрийн эрх, хэмжээг судалжээ. Судалгаанд аймаг, сумын үндсэн татвар болох 18 нэр төрлийн татварыг зохицуулж буй хууль, тогтоомжийн судалгааг хийж, орон нутгийн захиргаадын эдгээр татварыг ногдуулах, хувь хэмжээг нь тодорхойлох, хөнгөлөх, чөлөөлөх, хураах, орлогоо өөртөө төвлөрүүлэх зэрэг эрх мэдлийг үнэлж дүгнэлт өгөв. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа хоёр аймгийн төв, тэдгээрийн дөрвөн сумын 70 гаруй албан тушаалтантай уулзаж ярилцсан байна.

Санхүүгийн төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд боловсролын салбарын үүрэг функцийн хуваарилалтын талаарх судалгааны ажлыг ННФ хийлээ. Энэхүү судалгаанаас төв Засгийн газар, орон нутгийн удирдлага болон сургууль тус тусдаа ямар чиг үүрэгтэй болохыг тодорхой харж болох бөгөөд цашид эдгээрийг хэрхэн боловсронгуй болгох талаарх саналыг боловсруулахаар бэлтгэж буй юм.



Нийгмийн  
бодлого

## Нийгмийн хамгаалал

Нийгмийн даатгалын сангүүд, ялангуяа тэтгэврийн даатгалын сангийн ил тод байдлын асуудлууд эрх зүйн хувьд хэрхэн баталгаажсан байгаад дүн шинжилгээ хийх ажлыг Нээлттэй Нийгэм Форум 2008 онд шинээр эхлүүллээ. Эдгээр сан нь мөнгөн гүйлгээний тайланг тогтмол гаргадаг авч мэдээллийг олон нийтэд хүргэх хуулиар хүлээсэн үүрэггүй, зөвхөн шимтгэл төлөгч хувийн мэдээлэл, тайлбар авах зорилгоор даатгалын байцаагч, байгууллагад хандаж болох ерөнхий заалт нь сангийн үйл ажиллагааг бүхэлд нь ил тод болгоход хангалтгүй байгаа юм. Иймээс тэтгэврийн сангийн ил тод, хариуцлагатай үйл ажиллагааны зарчмуудыг холбогдох хуулиудад суулгах талаарх зөвлөмжийг Монголын нөхцөлд тохируулан судлах ажлыг цаашид хийхээр төлөвлөж байна.

Түүнчлэн ННФ эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо, эрүүл мэндийн даатгалын бодлогын орчинг боловсронгуй болгоход анхаарлаа хандууллаа. Тухайлбал, ННФ-ын бодлогын судлаач Д.Чимииддагва эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог судалж, шийдэх шаардлагатай асуудлуудыг тоймлон гаргасан болно. Судалгаанаас үзэхэд эрүүл мэндийн

салбарын санхүүжилтийн дийлэнх хэсэг нь хэвтэн эмчлүүлэх үйлчилгээнд зарцуулагдаж, харин өвчинөөс сэргийлэх зорилготой нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд хөрөнгө дутагдаж байгаа нь энэ салбарын хөрөнгө хуваарилалт, зардлын үр ашгийг нухацтай судлах шаардлагатайг харуулж байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь салбарыг санхүүжүүлэхэд нэмэлт хөрөнгө дайчлах үүргээ хангалттай биелүүлж байгаа ч даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргээ биелүүлж чадахгүй байна. Цаашлаад эрүүл мэндийн даатгалын төлбөрийг эмнэлгийн үйлчилгээний чанарт хийсэн хөндлөнгийн хяналтын үндсэн дээр тооцдог болох арга замыг 2008-2009 оны Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд судлахаар төлөвлөж байна.

Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, хүний эрхийн тодорхой зарчмуудыг эрүүл мэндийн бодлогод тусгах, энэ асуудлаар олон нийтэд мэдээлэл түгээх зорилго бүхий бус байгууллагуудыг чадавхижуулах төслийг ННФ 2008 оноос эхлэн хэрэгжүүлэхээр боллоо. Төслийн үр дүнг зөв тодорхойлох, хэрэгцээ шаарлагыг судлах зорилгын хүрээнд 2008 онд Украины Эмнэлгээр Үйлчлүүлэгчдийн Аюулгүй байдал, Эрхийг Хамгаалах байгууллагуудын зөвлөлөөс санаачлан хэрэгжүүлж буй бус нутгийн санаачилгад оролцсон бөгөөд тавдугаар сард тус улсын Киев хотноо зохиогдсон анхны уулзалтад Монголын ЭМЯ-ны мэргэжилтнийг оролцуулсан нь эмнэлгээр үйлчлүүлэгчдийн асуудлаар бодлого боловсруулагчдад зохих мэдлэг мэдээлэл хүргэх ач холбогдолтой байлаа. Мөн 2008 оны 11 дүгээр сард Казахстан улсын Алма Ата хотноо зохион байгуулагдсан хоёрдахь шатны уулзалтад Монголын Гемофилигийн Холбоо, Монголын Нийтийн Эрүүл Мэндийн Ажилтнуудын Холбоо, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэнгийн ажилтнуудыг оролцуулж туршлага судлуулав.

Түүнчлэн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн эрхийн байдлыг судлах зорилгоор Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд сэдэв зарлаад байна.

## Боловсролын чанар, хүртээмж



Нээлттэй Нийгэм Форум 2008 онд боловсрол, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр өмнө хийж байсан ажлаа улам гүнзгийрүүлэн боловсролын үйлчилгээний чанарыг салбарын дотоод үзүүлэлтүүд бус харин суралцагсын нийгмийн хэрэгцээг хангах мэдлэг, чадвар эзэмших орчинг аль хэр бүрдүүлж байгаагаар үнэлэх оролдлого хийлээ.

ЮНЕСКО-гийн санхүүжилтээр ННФ 2008 онд Монголын боловсролын салбарын ХДХВ/ДОХ/-оос сэргийлэх бодлогын орчны үнэлгээг хийв. Судалгаанаас үзэхэд, ХДХВ/ДОХ/-ийн талаар боловсрол олгох явдлыг 1997 оноос зорилт болгон тавьж ирсэн боловч хэрэгжилт нь нэн хангалтгүй байна. ХДХВ/ДОХ/-оос урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, сурх бичиг зохиох, сургагч багш бэлтгэх ажлыг гаднын донор байгууллагуудын тусламжтайгаар 1999-2003 онд эхлүүлсэн хэдий ч үргэлжлүүлэн нэгдсэн

бодлоготойгоор цогцоор нь хэрэгжүүлээгүй байна. Зөвхөн ДОХ, Сүрьеэ, Хумхаагаас сэргийлэх Глобал Сан, НҮБ-ын Хүн Амын Сан, ЮНЕСКО, Германы Хамтын Ажиллагааны GTZ зэрэг донор байгууллагуудын санхүүгийн болон мэргэжлийн туслалцаанд найдсан хэвээр байна. БСШУЯ-ны бүтцэд эрүүл мэнд, ДОХ-ын боловсрол хариуцсан түшмэл нь хүүхэд хамгаалал, “Үдийн цай” зэрэг үндэсний болон салбарын нийт 18 хөтөлбөрийн бодлого, зохицуулалтын ажлыг зэрэг хийдэг төдийгүй зөвхөн бага, дунд боловсролын бодлого хариуцсан бүтцэд багтаж ажилладаг тул залуучууд олноор хамрагддаг дээд боловсрол болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн боловсролын оюутан, багш нарт хүрч ажиллаж чадахгүй байна. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн агуулгын хүрээнд БЗХ/ДОХ/ХДХВ-ээс сэргийлэх боловсрол эзэмшсэн сургачдын дунд халдвараас сэргийлэх арга замын тухай мэдлэг харьцангуй өндөр байгаа ч зан үйл болгож амьдралдаа хэрэглэх нь тун доогуур үзүүлэлттэй байгааг 2007 онд Эрүүл Мэндийн Яамнаас хийсэн тандалт судалгааны дүн харуулжээ. ХДХВ/ДОХ/-оос сэргийлэх сургалтыг албан боловсролын агуулгад багтаасан амжилтыг бэхжүүлэх зорилгоор судалгааны дүгнэлтэд тулгуурлан БСШУЯ-ны түвшинд энэ ажлын хэрэгжилтийг дэмжих оновчтой бүтэц, үйл ажиллагааны стратегийг санал болголоо.

Сүүлийн жилүүдэд сургууль завсардалтын хэмжээ өсөх болсонтой холбоотойгоор бодит шалтгааныг нь олж судлах, боловсролын салбарын бодлогын үр өгөөжийг үнэлэх арга зүйг боловсруулах ажлыг хийж байна. Тухайлбал, засаг захиргааны үндсэн нэгж болох хорооны бүртгэлийг ашиглан сургуулийн насны хүүхдүүдийг тоолж, сургуульд сурахгүй байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг кейс судалгаагаар нарийвчлан тодорхойлох арга зүйг боловсрууллаа. Сургууль завсардалтын дүн мэдээг зөвхөн сургуулиар дамжуулан бүрдүүлснээс сургуульд огт элсээгүй хүүхэд боловсролын албан ёсны статистикт тусахгүй байгаа нь энэ судалгааны явцад ажиглагдажээ. Судалгааг ННФ-ын захиалгаар Зохистой Хөгжлийн Жендер Төв, Филантропи төв зэрэг төрийн бус байгууллага Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийн хороо, хэсэг дээр хийж буй бөгөөд тайлан нь 2009 онд гарах юм.

ННФ 2008 онд сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх зорилгоор Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ-ын “Алхам алхмаар” хөтөлбөрт дэмжлэг үзүүлэв. Хүүхэд төвтэй сургалтын арга зүйг цэцэрлэг, бага ангийн багш нар, эцэг эхчүүдэд эзэмшигүүлэх зорилготой энэ хөтөлбөр нь эцэг эх, орон нутаг руу чиглэсэн нөлөөллийн ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд хамгаалал болон бага насны хүүхдийн боловсролын асуудалд онцгой анхаарч дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

# ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

Нээлттэй Нийгэм Форум 2008 онд эмзэг бүлгийн буюу нөхцөл боломж хязгаарлагдал хүүхдүүдийн хөгжлийг дэмжих зорилготой хичээлээс гадуурх хөтөлбөр боловсруулах чадавхийг орон нутагт байгаа нөөц боломжид түшиглэн бүрдүүлэх ажлыг эхлүүллээ. Сургуулийн насны хүүхдийн чөлөөт цагийн хөтөлбөрүүд нь тэдний чөлөөт цагийг зөв зохион байгуулах үр ашигтай арга болохын зэрэгцээ нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хувь хүний үр чадварыг хөгжүүлэх үр өгөөжтэй хэлбэр болдог. Иймээс орон нутаг дахь материаллаг болон хүний нөөцийн боломжуудыг дайчлан хүүхдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлж туршлага хүримтлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд хөгжүүлэх хичээлээс гадуурх хөтөлбөр”-ийн төслийг ННФ хэрэгжүүлж байна. Олон нийтэд нээлттэй зарласан энэхүү уралдаант шалгаруулалтад Улаанбаатар хотын зах болон аймгийн төвийн гурван номын сан, нэг төрийн бус байгууллагын төслүүд шалгарлаа. Эдгээр байгууллага 2009 оны хоёрдугаар сард ННФ-аас зохион байгуулах сургалтад хамрагдсаны дараа үйл ажиллагаагаа эхлэх юм.

## Шалгарсан төслүүд:

Байгууллага	Төсөл
“Сод Номун” ТББ	Улаанхуаран дахь гэр номын санг түшиглэн сар сараар тодорхой сэдэв сонгож энэ сэдвээрээ ном унших ярих, жүжиг тавих, уулзалт зохион байгуулах, аялал хийх зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах юм. Тэтгэврт гарсан ахмадууд, өрхийн эмч зэрэг хүмүүсийг дайчлан ажиллуулна.
Баянхонгор аймгийн нийтийн номын сан	Аудио ном, мультимедиа хэрэгслүүдийг ашиглан, мөн харилцан туслалцах зарчмаар хөгжлийн бэрхшээлтэй болон жирийн хүүхдүүдийг бүлэг байгуулж ажиллана.
Орхон аймгийн номын сан	Залуу сэтгүүлчдийн клуб, Экологийн клуб, Эрүүл мэндийн клуб (ахмад сэтгүүлчид, эцэг эхчүүд, эмч нар) ажиллуулна.
Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Амьдралын боломж муутай өрхийн хүүхдүүдийг төрийн бус байгууллагуудад дадлага хийлгэж ажлын туршлага олгох замаар идэвхжүүлнэ.



# Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

## Хөгжлийн мэдээллийн төв

Нээлттэй Нийгэм Форумын Хөгжлийн Мэдээллийн төв 2008 оноос эхлэн онлайн гишүүнчлэлийн үйлчилгээг туршиж эхэллээ. Өдөр тутмын гол хэрэглэгчид (i) онлайнаар, (ii) гэрээр ном авах үйлчилгээг сонгож байгааг үндэслэн энэхүү үйлчилгээг уншигчдад санал болгосноор байгууллагаараа гишүүнчлэлийн багц үйлчилгээ авах эрэлт хүсэлт нэмэгдэх хандлагатай байна. Одоогоор 20 гаруй хувь хувь хүн, нэг байгууллага уг үйлчилгээг авч байна.

Тус төвөөс 2008 онд нийтдээ 3,000 орчим хүн мэдээллийн үйлчилгээ авч 2,100 орчим ном, судалгаа гэрээр уншигдан онлайн каталогиос ([http://www.soros.org.mn/osf\\_opac](http://www.soros.org.mn/osf_opac)) 10,000 гаруй удаа мэдээллийн хайлт хийгджээ. Статистикаас харахад ажлын нэг өдөрт дунджаар 10 гаруй хүн төвд ирж, 200 гаруй хүн ямар нэг хэмжээгээр онлайн үйлчилгээ авч, 10 орчим ном судалгаа гэрээр гарч, жилдээ 200 орчим ном судалгаа шинээр иржээ.

Хөдөө орон нутгийн номын санд шинэ мэдээлэл хүргэх, номын санчдыг чадавхижуулах чиглэлээр тодорхой санал санаачилга хэрэгжлээ. Тухайлбал, Өмнөговь аймгийн төвийн нийтийн номын санд Соросын сангийн тусламжаар 2000 онд байгуулсан Интернэт төвийг Дэлхийн Банк, Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төвтэй хамтран Хөгжлийн мэдээлэл сургалтын төв болгон шинэчилж өргөтгөлөө. Энэ нь орон нутагт номын сан түшиглэн ажиллаж байгаа хөгжлийн мэдээлэл түгээх хоёр дахь төв болж буй бөгөөд орон нутгийн иргэд улс орны хөгжлийн бодлогын асуудлыг хэлэлшэх, мэдлэг мэдээлэл олж авах боломжтой боллоо. Аймаг, сумын нийт 300 гаруй нийтийн номын санд ННФ-аас хэвлэн гаргасан ном, судалгааг шуудангаар дамжуулан тогтмол хүргэж 2008 онд 15,000 орчим ном түгээлээ.

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Мэдээлэл, Харилцаа, Холбоо, Технологийн Газар, Дэлхийн Банк, eIFL.net –тэй хамтран мэдээллийн

ажилтнуудын мэдлэг мэдээлэл түгээх ур чадварыг дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулж 32 номын сангийн 50 гаруй номын санч оролцлоо. Ингэснээр мэдээллийн технологийн эрин үед номын сан, мэдээллийн төвийн үйл ажиллагаанд гарч байгаа хөгжил дэвшил, бэрхшээл хүндрэлийн талаар хэлэлцэн Номын сангийн консорциум байгуулж, улмаар бусад орны электрон мэдээллийн санг захиалах зэргээр орчин үеийн хэрэглэгчдэд шаардлагатай байгаа мэдлэг, мэдээллийг номын сангүүдад бий болгох алхам хийгдлээ. Түүнчлэн Хөгжлийн мэдээллийн төв нь eFL.net –ийн Үндэсний номын санг шинэчлэх стратеги төлөвлөлтийн судалгаа, сургалт зохион байгуулах төсөл дээр хамтран ажиллаж байна.

АНУ-ын Конгрессийн номын сангийн ном солилцооны хөтөлбөр, Дэлхийн Банкны ном захиалга болон Азийн Хөгжлийн Банкны хэвлэлийн газруудтай түншлэн 2008 онд эдгээр байгууллагаас нийтдээ 100 орчим ном, судалгаа хүлээн авсан байна.

Цаашид Хөгжлийн Мэдээллийн төв онлайн болон гишүүнчлэлийн үйлчилгээний зохистой харьцааг хадгалж чанартай мэдээллийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр аль болох олон хүнд хүргэх бодлого баримталж байна.

# Портал сайт “www.forum.mn”

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлээр 2008 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

## Нийтлэл & News headlines

2008 онд Монголын хөгжлийн талаар 50 гаруй нийтлэл, өгүүллийг олны хүртэл болгосон байна. Нийтлэл буландаа нийтдээ 270 орчим нийтлэл агуулагдаж байна. Зонхилох сэдвүүд нь засаглалын асуудлууд, татвар, уул уурхай, байгаль орчин, хүн амын амьжиргаа, хүнс, хөдөө аж ахуй, гадаад, дотоод бодлого, даяаршлын тухай бөгөөд эрдэмтэн судлаачид, багш нар, сэтгүүлч, төрийн албан хаагчид өөрсдийн бичсэн нийтлэл, өгүүллээ нийлүүлжээ. Түүнчлэн Монголын улс төр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг тогтмол хүргэдэг “Онцлох мэдээ” буландаа 300 гаруй үйл явдлын тухай мэдээлэл хуримтлагдажээ/2005 оны сүүлээр эхэлсэн/. Тойм өгүүллийг өдөр тутмын сонин хэвлэлүүдийн мэдээлэлд үндэслэн өдөр бүр байнга шинэчилдэг бөгөөд эндээс Монголын хувьд тухайн жил сард бодлогын холбогдолтой ямар үйл явдлууд өрнөж олон нийтийн анхаарлыг татаж байсныг харах бүрэн боломжтой юм.

## Тогтмол явуулдаг ажиглалтууд:

### Сонгуулийн ажиглалт

2008 онд Монгол Улсын хувьд ихээхэн чухал үйл явдал болох Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулиуд болсон. Үүнтэй холбогдуулан манай портал “Сонгууль-2008” ажиглалтыг явууллаа. Энэ ажиглалт нь улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн дүн, нэр дэвшигчид, сонгуулийн кампанит ажлын явцын талаарх мэдээ мэдээлэл, намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх шүүмж анализ, сонгуулийн үйл явцын мониторинг зэрэг өргөн хүрээтэй мэдээ материалыг нэг дор байрлуулан, олон нийтдээ түргэн шуурхай танилцах боломжийг бүрдүүлж, нийтдээ 100 орчим мэдээ, мэдээллийг багцаар нь хүргэжээ.

### Үүл уурхай – Хөгжил

2008 онд Монголын үүл уурхайн салбар олны анхаарлын төвд байсан хэдий ч Оюу толгой, Таван толгой, Асгат зэрэг томоохон ордуудын хөрөнгө оруулалтын гэрээ зогсонги байдалд орсон хэвээр байлаа. Энэ бүхий үйл явдлын талаарх цогц мэдээллийг манай портал хүргэсээр ирсэн агаад 2007 онд 80 гаруй мэдээллийг олон нийтэд хүргэжээ. Стратегийн орд газруудын тухай мэдээллийг агуулсан тусгай хуудас эхлүүлж тэдгээрт холбоотой мэдээллийг цуглуулж байна.

### "Төсвийн үйл явц"

Тус портал нь 2004 оноос эхлэн жил бүрийн үлсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллүүдийг тогтмол толиуулдаг болсон. Тайлангийн хугацаанд 2008 оны төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, үлсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох нийт 40 мэдээ, мэдээллийг түгээлээ. Тухайн жилийн үлсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь вэб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг нь хүлээн авч хэвшлээ. Түүнчлэн төсвийн талаарх мэдээлэлд мэргэжлийн судлаачдаар шүүмж анализ хийлгэн хөндлөнгийн хяналт бий болгоход анхаарч байна.

### "Доноруудын тусlamж"

Олон үлсын байгууллага, хандивлагчдаас Монгол Улсад үзүүлж тусlamж, зээлийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллээр хэрхэн хүргэж буйг ажиглах зорилгоор "Доноруудын тусlamж" ажиглалт буланг нээлээ.

### Бодлогын асуудал

"Бодлогын асуудал" буланд хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог боловсронгуй болгоход чиглэсэн холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын төсөл, УИХ-ын Сонгуулийн хуулийг дагалдан гарах журмууд /нийт 15 журам, 13 баримт бичгийн төсөл/, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Сонгуулийн үйл явцын эрх зүйн зохицуулалт,

2008 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн гол намуудын амлалт болох “Эх орны хишиг буюу Эрдэнийн хувь” зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор тэдгээртэй холбоотой баримт бичиг, судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулсан байна. Тайлант хугацаанд 30 гаруй мэдээллийг шинээр оруулсан бөгөөд эдгээр асуудлаар одоогийн байдлаар 40 гаруй хүн санал бодлоо илэрхийлжээ.

### **Эх сурвалж**

Тайлангийн хугацаанд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 50 орчим шинэ судалгааг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2008 онд портал сайтад нийт 130 гаруй мянган хүн, өдөрт дунджаар 500 орчим хүн нэвтэрчээ.

## Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр

Нээлттэй Нийгэм Форум хавсарга судалгааны нэг чиглэл болох бодлогын судалгаа, дүн шинжилгээг Монголд хөгжүүлэх зорилгоор Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг 2004 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Эдүгээ бодлого боловсруулагчын дунд ННФ-ын бодлогын судалгааны хөтөлбөрийн тайлангуудыг ашиглах явдал нэмэгдэж байгаагийн зэрэгцээ бодлогын судалгааны арга зүйн туслалцаа дэмжлэгийг эрэлхийлэх байдал ажиглагдах боллоо. Түүнчлэн хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн судлаачдын тоо ч нэмэгдэж байна.

2008 онд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн загварт хоёр томоохон өөрчлөлт орлоо. Бодлогын судалгааны арга зүйг эзэмшүүлэх үндсэн хөтөлбөрийн зэрэгцээ “Ахлах судлаач” хөтөлбөрийг шинээр бий болголоо. Энэ хөтөлбөрт өндөр түвшний аналитик судалгаа хийх чадвартай хүмүүсийг сонгон хамруулж, ННФ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр чанартай сайн тайлан гаргаж хэрэгжүүлэх нөхцлөөр хангана. Энэ хөтөлбөрийн зорилго нь бодлогын судалгааны ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлэх явдал юм. Хоёрдугаарт, хувь судлаачдаас гадна хөтөлбөрийн хүрээнд багийн судалгаа хийх явдлыг дэмжих болов. Хүмүүсийн давуу талуудыг илүү үр бүтээлтэйгээр хослуулснаар бодлогын судалгаа эрчимжиж, тайлангийн чанар сайжран, багаар ажиллах чадвар нэмэгдэнэ хэмээн ННФ үзэж байна.

### **2008 онд бэлэн болсон бодлогын судалгааны тайлан**

<b>Судлаач</b>	<b>Судалгааны тайлан</b>
Л.Мөнх-Эрдэнэ	Төрийн өмчийн их сургуулийн удирдлагын шинэчлэл: олон нийтийн статус, хамтын удирдлага
Б. Арвинбаяр	Импортын урьдчилсан хяналтын тогтолцоог институуцилах замаар хүнсний чанарын баталгааг хангах нь
С.Батсүх	Инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлого
Ч. Базар	Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийг дэмжсэн эрх зүйн болон үйл ажиллагааны орчин бүрдүүлэх арга зам
Д.Чимиддагва	Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо
Н. Мягмарцоож	Төрөөс хяналт шалгалтын чиг үүргээ гүйцэтгэхэд иргэд, төрийн бус байгууллагын оролцох боломж
Э. Гэрэлт-Од	Улс төрийн намын дотоод ардчилал
Т. Батзориг	Олон нийтийн радио телевизийн санхүүжилт
Л. Мөнх-Эрдэнэ	Эмнэлгийн байгууллагын чанар, санхүүжилтийн уялдаа

## Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр

Нээлттэй Нийгэм Форум 2007 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн (Будапешт, Унгар Улс) Дээд боловсролыг дэмжих хөтөлбөрөөс хэрэгжүүлдэг Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрийн Монголд дахь үйл ажиллагааны зохицуулагчаар ажиллаж байна. Энэ хөтөлбөр нь нийгмийн ухааны сургалт судалгааны ажлыг дэмжих замаар дээд боловсролын шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилготой юм. Хөтөлбөрт Зүүн ба Өмнөд Европ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан орнууд болон Монгол Улсын төрийн болон олон нийтийн их дээд сургуулиуд хамрагддаг.

2008-2009 оны хичээлийн жилд Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрт МУИС-ийн Нийгмийн Ухааны сургуулийн Нийгэм, Соёлын антропологийн тэнхим, Эдийн Засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим, МУБИС-ийн Нийгмийн ажилтны тэнхим, ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн сургуулийн дөрвөн тэнхим, нийт 19 багш хамрагдан ажиллаж байна. Өмнөх жилтэй харьцуулахад түнш тэнхмийн тоо нэмэгдээгүй ч хөтөлбөрөөс дэмжлэг авч байгаа багшийн тоо наймаар нэмэгдлээ. Хөтөлбөрт гадаадын нэр хүндэтэй их, дээд сургуулиас магистр болон түүнээс дээш зэрэг хүртсэн багш, энэ шаардлагыг хангасан хоёроос доошгүй багштай нийгмийн ухааны тэнхмүүд хамрагдах эрхтэй. 2008 онд ННФ-ын зохицуулагч Монголын төрийн мэдлийн их дээд сургуулиудад хөтөлбөрийн талаар мэдээлсний үр дүнд ирэх хичээлийн жилд хоёр тэнхим шинээр оролцох хүсэлтээ илэрхийлээд байна. Бусад сургуулиас хөтөлбөрт оролцох хүсэл, сонирхлоо илэрхийлсэн авч тавигдаж буй шаардлагыг хангаж чадахгүй байгаа тул ННФ хөтөлбөрт хамрагдах нөхчлийг бүрдүүлэхэд нь зөвлөгөө өгч ажиллах болно.

Түнш тэнхим, багш нарын сургалтын шинэчлэл, судалгааны ажлыг дэмжих зорилгоор гадаадын зөвлөхийн дэмжлэгээр хангаж өгөх үүргийг хөтөлбөр хүлээдэг. 2008-2008 он хичээлийн жилд Английн Кембриджийн Их Сургуулийн Монгол болон Өвөр Ази судлалын төв, АНУ-ын Албани дахь Нью Йорк мужийн Их сургуулийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, Колумбийн Их Сургуулийн Нийгмийн Ажилтны Сургууль, Виржини мужийн Мелвилл Их сургууль зэрэг дэлхийд танигдсан сургуулиудын сургалт, судалгааны арга зүйн туршлагыг монгол багш нарт дамжуулахаар зургаан зөвлөх багш ажиллаж байна.

Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байгаа Монгол багш нар интернет сүлжээгээр бусад орны түнш тэнхим, багш нартай холбоотой ажиллаж өөрсдийн боловсруулж байгаа сургалтын хөтөлбөр, судалгааны ажил дээрээ зөвлөгөө, санал авах боломжтой. Мөн гадаадад зохиогдож байгаа олон улсын хуралд оролцож илтгэл тавих, докторын зэрэг горилох болон бусад төрлийн судалгааны ажлаа ахиулах зорилгоор тодорхой хугацаагаар гадаадын сургууль, номын санд очиж ажиллахад нь хөтөлбөрийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Хөтөлбөрт хамрагдаагүй ч үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байгаа түнш тэнхмийн бусад багш нарыг дэмжих зорилгоор өөр орны ижил чиглэлийн түнш тэнхим дээр очиж туршлага судлах богино хугацааны аяллын тэтгэлгийг 2008 оноос шинээр хэрэгжүүлж эхлээд байна.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа англи хэл дээр явагддаг.

## ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд мониторинг хийх үйл явцад иргэд, иргэний нийгмийн байгууллагууд жил ирэх тутам идэвх санаачилгатай, тодорхой арга хэлбэрээр оролцож байгаагийн үр дүнд төр, засгийн гаргаж буй шийдвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Энэ нь ихэнхидээ олон нийтийн хэлэлцүүлэг, телевиз, радиогийн ярилцлагад оролцох, тухайн асуудлаарх судалгааны дүн мэдээг тарааж түгээх байдлаар явагдаж буй юм. Оролцооны аль ч шатанд иргэд, иргэний нийгмийнхэн, бодлого боловсруулагчид найдвартай эх сурвалжийн бодит мэдлэг мэдээллийг цаг алдалгүй олж авах нь нэн чухал билээ. Энэхүү ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2003 оноос эхлэн судалгааны тайлан, иргэдэд зориулсан гарын авлага, ном зүйн цуврал, эдийн засаг, улс төр, ардчилал, иргэний нийгмийн хөгжлийн сэдвээр 100 гаруй нэрийн ном хэвлэн гаргалаа.

ННФ-аас эрхлэн гаргасан иргэдэд зориулсан эрх зүйн гарын авлага, сонгуулийн тухай ном, иргэний нийгмийн байгууллагад зориулсан татвар, төсвийн болон мониторингийн гарын авлага, бодлогын судалгааны тайлан нь нэлээд эрэлт сайтай, олны танил бүтээгдэхүүн болж чадлаа. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм, жил бүр төрийн ил тод байдлаар хийж байгаа форумын эмхтгэл зэрэг цуврал номууд нь зөвхөн ННФ-ын бүтээгдэхүүн болж байгаагаараа онцлогтой юм.

2008 онд хөтөлбөрүүдийнхээ хүрээнд нийт 22 ном хэвлүүлснээс судалгааны тайлан долоо, иргэдэд зориулсан гарын авлага гурав, 12 ном зүйн цуврал, орчуулгын номыг олны хүртээл болгов. Эдгээр бүтээгдэхүүнээс заримыг дурдвал:

- Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тойм-2007 /Судалгааны тайлан/
- Иргэдэд зориулсан эрх зүйн хөтөч /гарын авлага, 2 дахь хэвлэл/
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, эмнэлгийн санхүүжилт /Бодлогын судалгааны тайлан/
- Инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлого /Бодлогын судалгааны тайлан/
- Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийг дэмжсэн эрх зүйн болон үйл ажиллагааны орчин бүрдүүлэх арга зам /Бодлогын судалгааны тайлан/
- Хүнсний чанарын баталгааг хангах нь /Бодлогын судалгааны тайлан/
- Төрийн үйлчилгээний мониторинг 2007 /ТББ-уудын мониторингийн тайлангийн эмхтгэл/
- Төрийн ил тод байдал: Шударга сонгууль /Форумын эмхтгэл/
- Ардчилсан сонгууль: Иргэний нийгмийн хяналт /Хурлын эмхтгэл/
- Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэл /Баримтжуулалтын тайлан/
- Сонгуульд суралцахуй /Гарын авлага/
- Сүйрэл /Орчуулга/
- Ардчиллын хэв загвар /Орчуулга/

Эдгээр ном, судалгааны тайланг аймаг, сумын 330 гаруй номын сан, нийтийн болон их дээд сургуулийн номын сан, төрийн бус байгууллагууд, УИХ-ын гишүүд, Форумын уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдод байнга түгээж байна.

# Орчуулгын төсөл

Зохиол бүтээлээрээ олон оронд нэрд гарсан алдартай зохиогчдын нийгэм-эдийн засаг, улс төр, хөгжлийн сэдвээр гарсан номыг эх хэлнээ орчуулж хэвлэн олны хүртээл болгох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2004 оноос эхлэн Орчуулгын төсөл хэрэгжүүлж эхэлсэн билээ. Орчуулгын төсөл нь иргэдийн иргэний боловсролд тус нэмэр болоод зогсохгүй, төрийн үйлчилгээнд мониторинг хийх, тодорхой сэдвээр нийгэмд өрнөж буй олон нийтийн хэлэлцүүлэгт мэдлэг, мэдээлэлтэй оролцох, тухайн салбарын бодлогыг хүчирхэгжүүлэхдэд хувь нэмрээ оруулах чухал нөлөөтэй юм.

Төслийн хүрээнд 2004-2006 онд “МонСудар” хэвлэлийн газартай хамтран 10 гаруй ном орчуулж хэвлэн зах зээлд хямдralтай үнээр борлуулж байгаагаас одоогийн байдлаар 3-4 нэрийн ном зарагдаж дуусаад байна. Форум 2007 оноос эхлэн энэхүү төслийг дангаараа үргэлжлүүлж 2007 -2008 онд “Боловсролын бодлогын импорт”, “Эдийн засаг энгийнээр”, “Ардчиллын дүр төрх”, “Сүйрэл” зэрэг номыг орчуулан зах зээлийн үнээр борлуулж дараа дараагийн ном орчуулах сан бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

Цаашид уг төслийн хүрээнд хэвлэгдэх номын орчуулгын чанарт түлхүү анхаарах, олон нийтэд танилцуулах, номын сэдвээр их дээд сургууль, номын дэлгүүрүүдэд уулзалт, ярилцлага хийх, телевиз, радиогийн шинэ номын булан нэвтрүүлгүүдэд оролцох зэргээр номыг сурталчлах, мэдлэг, мэдээллийг илүү үр өгөөжтэй түгээх болно.

## Бусад

### “ДОРНО ДОРНО - ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ” БҮСИЙН ХӨТӨЛБӨР

Дорно Дорно хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх, түүнийг бэхжүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хил хязгааргүй түншлэлийг дэмждэг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн бүсийн хөтөлбөр бөгөөд Нээлттэй Нийгэм Форум Монгол дахь үйл ажиллагааг нь хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааг бүсийн хэмжээнд бэхжүүлэхэд түлхэц болох шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Хоёр буюу түүнээс дээш орныг хамарсан төслүүдийг дэмждэг болно.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэдэрч дороос гарч ирсэн санаачилгуудад анхаарлаа хандуулж, нээлттэй нийгмийг хөгжүүлэх нийтлэг зорилгод хүрэхийн тулд хүмүүс хил хязгаарыг харгалзахгүйгээр хүч хавсрсан ажиллах боломжийг нэмэгдүүлэхийг урт хугацааны зорилго болгодог юм. Хөтөлбөрийн хүрээнд бүсийн орнуудад зохиогдож буй шинэлэг санаа, арга туршлагаа хуваалцаа зорилго бүхий арга хэмжээнд Монголын мэргэжилтэн, төлөөлөгчдийг хамруулж байна.

#### 2008 онд Дорно Дорно хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдлагасад

№	Оролцогчдын нэрс	Байрлал	Хурал семинар зохион байгуулагдсан газар болон агуулга	Огноо
1	С.Цэрэндорж (Хүний эрх ардчиллын судалгааны төвийн гүйцэтгэх захирал)	Москва хот ОХУ	Сонгуулийн ажиглалт	2008 оны 2 сарын 4-8
2	Д.Энхцэцэг (Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын асуудал хариуцсан менежер)	Москва хот ОХУ	Сонгуулийн ажиглалт	2008 оны 2 сарын 4-8
3	Г. Батжил (“Орос Гимнази” сургуулийн захирал)	Улаан үд хот ОХУ	Нээлттэй сургууль сургалт	2008 оны 3 сарын 27-ноос 4 сарын 6

4	Л.Цэрэнханд (23-р дунд сургуулийн нийгмийн ажилтан)	Улаан үд хот ОХУ	Нээлттэй сургууль сургалт	2008 оны 3 сарын 27-ноос 4 сарын 6
5	Г.Долгормаа (Сүхбаатар аймгийн Дарьганга сумын дунд сургуулийн захирал)	Улаан үд хот ОХУ	Нээлттэй сургууль сургалт	2008 оны 3 сарын 27-ноос 4 сарын 6
6	Н.Нарантуяа (Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн менежер)	Улаан үд хот ОХУ	Нээлттэй сургууль сургалт	2008 оны 3 сарын 27-ноос 4 сарын 6
7	Н.Нарантуяа Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн менежер	Одесс хот Украина улс	Олон нийт болон сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх: туршлага судлах аялал	2008 оны 7 сарын 19-27
8	Р.Банди (Монголын Боловсролын Нийгэмлэгийн Удиরдах Зөвлөлийн Гишүүн)	Одесс хот Украина улс	Олон нийт болон сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх: туршлага судлах аялал	2008 оны 7 сарын 19-27
9	Б.Дэлгэрсайхан (Эрүүгийн Цагдаагийн Газрын ахлах мөрдөн байцаагч)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
10	Ж.Бат-Эрдэнэ (Иргэний Бүртгэл Мэдээллийн төвийн орлогч захирал)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
11	С.Болд (Гадаадын Иргэн Харьяатын Асуудал Эрхлэх Албаны гадаад харилцааны зохицуулагч)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
12	Э.Энх-Амгалан (Хүний Наймааны Асуудлаарх Хөтөлбөрийн ажилтан)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26

13	Б.Эрдэнэбадрах (Хууль зүй Дотоод Хэргийн Яамны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын ажилтан)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
14	Ө.Эрдэнэчимэг (Хүйсийн Тэгш Эрхийн Төвийн Олон улсын харилцааны ажилтан)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
15	Г.Ганбаясгах (Хүйсийн Тэгш Эрхийн Төвийн тэргүүн)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
16	Э.Хишигбаяр (Хүйсийн Тэгш Эрхийн Төвийн Хөтөлбөрийн зохицуулагч)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
17	Т.Цогзолмаа (Хүйсийн Тэгш Эрхийн Төвийн Хөтөлбөрийн зохицуулагч)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
18	Д.Түмэнбаяр (Замын- Үүдийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн ахлах мөрдөн байцаагч)	Прага хот Чех Улс	Хүний наймааны асуудлаар Чех Монгол улсын туршлага солилцох семинар	2008 оны 10 сарын 18-26
19	Г.Долгормаа (Сүхбаатар аймгийн Дарьганга сумын дунд сургуулийн захирал)	Лодз хот Польш улс	Нээлттэй сургууль семинар	2008 оны 10 сарын 23-31
20	Н.Нарантуяа (Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн менежер)	Лодз хот Польш улс	Нээлттэй сургууль семинар	2008 оны 10 сарын 23-31
21	Г.Батжил ("Орос Гимнази" сургуулийн захирал)	Лодз хот Польш улс	Нээлттэй сургууль семинар	2008 оны 10 сарын 23-31

22	Ж.Гүндэгмаа (Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал)	Алмата хот Казакстан улс	Өвчтөний эрхийн асуудлаарх Бүсийн уулзалт	2008 оны 11 сарын 13-15
23	Б.Сувд (Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны Төвийн менежер)	Алмата хот Казакстан улс	Өвчтөний эрхийн асуудлаарх Бүсийн уулзалт	2008 оны 11 сарын 13-15
24	Н.Мандаа (Монголын Цусны Өвчтэй Хүмүүст Туслах Нийгэмлэгийн зөвлөлийн тэргүүн)	Алмата хот Казакстан улс	Өвчтөний эрхийн асуудлаарх Бүсийн уулзалт	2008 оны 11 сарын 13-15

#### 2008 онд Дорно Дорно хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн төслүүд

№	Семинарын нэр	Байрлал	Огноо
1	"Сонгуулийн мониторинг" олон улсын семинар	Улаанбаатар хот, Монгол	2008 оны 3 сарын 28-29
2	"Цахим засаглал ба мэдээлэл, харилцаа холбоо технологийн бодлого" семинар	Улаанбаатар хот, Монгол	2008 оны 4 сарын 29-5 сарын 1
3	Гэр бүлийн хүчирхийллийн гинжин холбоог таслах /5 өдрийн сургалт/	Улаанбаатар хот, Монгол	2008 оны 6 сарын 23-30
4	Гэр бүлийн хүчирхийллийн гинжин холбоог таслах /5 өдрийн сургалт/	Улаанбаатар хот, Монгол	2008 оны 9 сарын 22-27
5	Гэр бүлийн хүчирхийллийн гинжин холбоог таслах /5 өдрийн сургалт/	Улаанбаатар хот, Монгол	2008 оны 11 сарын 9-14

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2008 онд нийт 1,520,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 967,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн, \$ 372,000 Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 58,000 Дэлхийн банк, \$ 109,000 Орлогын ажиглалтын хүрээлэн, \$ 14,000 нь бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

### Нийт зарцуулалт

ам. доллар

Хөтөлбөр	Бусад байгууллагад олгосон тэтгэлэг	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ</b>			
Чөлөөт, шударга сонгууль	89,030	85,438	174,468
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	20,900	497	21,397
ТТБ-уудын төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг	47,815	69,560	117,375
Иргэдийн оролцоо ба Мэдээллийн эрх чөлөө	6,920	10,720	17,640
Шүүхийн хараат бус байдал	-	3,027	3,027
Эрх зүйн туслалцаа	82,836	14,098	96,934
Стратегийн өмгөөлөл	22,600	-	22,600
<b>ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>			
Төсвийн мониторинг	58,467	40,106	98,573
Байгалийн баялгийн орлогын ил тод байдал ба менежмент	67,472	45,429	112,901
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	-	33,660	33,660
Бизнесийн орчин	-	7,268	7,268
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	1,782	98,393	100,175
<b>НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Нийгмийн хамгаалал	14,963	2,100	17,063
Боловсролын чанар, хүртээмж	34,386	10,996	45,382
Хүүхэд, залуучуудын хөгжил	71,355	758	72,113
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>			
Хөгжлийн мэдээллийн төв	-	40,375	40,375
Портал сайт	-	34,752	34,752
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	-	8,670	8,670
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр	-	13,761	13,761
Орчуулгын хөтөлбөр	-	4,454	4,454
Дорно Дорно хөтөлбөр	41,160	-	41,160
<b>ЗАХИРГАА</b>			
<b>Нийт дүн</b>	<b>559,686</b>	<b>786,337</b>	<b>1,346,023</b>

Нээлттэй Нийгэм Форум 2008 онд нийт 559,686 ам.долларын тэтгэлгийг байгууллага болон хувь хүмүүст олгосон байна. Нийт 54 байгуулага болон 34 хувь хүмүүст тус тус олгожээ.

### Тэтгэлгийн зарцуулалт

ам. доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Нийт
<b>АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ</b>			
Чөлөөт, шударга сонгууль	89,030		89,030
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	20,900		20,900
ТТБ-уудын төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг	47,815		47,815
Иргэдийн оролцоо ба Мэдээллийн эрх чөлөө	6,920		6,920
Шүүхийн хараат бус байдал			-
Эрх зүйн туслалцаа	67,346	15,490	82,836
Стратегийн өмгөөлөл	22,600		22,600
<b>ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>			
Төсвийн мониторинг	46,370	12,097	58,467
Байгалийн баялгийн орлогын ил тод байдал ба менежмент	54,315	13,157	67,472
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ			-
Бизнесийн орчин			-
Орон нутгийн эдийн засгийн хөгжил		1,782	1,782
<b>НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Нийгмийн хамгаалал	7,960	7,003	14,963
Боловсролын чанар, хүртээмж	4,367	10,019	34,386
Хүүхэд, залуучуудын хөгжил	71,355		71,355
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ:</b>			
Хөгжлийн мэдээллийн төв			-
Портал сайт			-
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр			-
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр			-
Орчуулгын хөтөлбөр			-
Дорно Дорно хөтөлбөр	41,160		41,160
<b>НИЙТ ДҮН</b>	<b>500,138</b>	<b>59,548</b>	<b>559,686</b>

**2008 онд олгосон тэтгэлгийн жагсаалт**

ам. доллар

<b>№</b>	<b>Тэтгэлэг хүртэгчийн нэр</b>	<b>Байршил</b>	<b>Төрөл</b>	<b>Тэтгэлгийн дүн</b>
1	Ардчиллын Боловсрол Төв	Улаанбаатар хот	ТББ	\$ 40,620
2	Архангай аймгийн Түвшрүүлэх сумын Ар Баян нөхөрлөл	Архангай аймаг	ТББ	\$ 3,000
3	Байгаль Оюу	Улаанбаатар хот	ТББ	\$ 7,100
4	Ховд аймгийн Баян Алтай Нөхөрлөл	Ховд аймаг	ТББ	\$ 2,080
5	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Улаанбаатар хот	ТББ	\$ 50,000
6	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Улаанбаатар хот	ТББ	\$ 5,490
7	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Улаанбаатар хот	ТББ	\$ 5,065
8	Глоб Интернэшнл	Улаанбаатар хот	ТББ	\$ 556
9	Глоб Интернэшнл	Улаанбаатар хот	ТББ	\$ 21,185
10	Глоб Интернэшнл	Улаанбаатар хот	ТББ	\$ 15,000
11	Захиргааны Шинэ Санаачилга	Улаанбаатар хот	ТББ	\$ 7,000
12	Зориг сан	Улаанбаатар хот	ТББ	\$ 5,050
13	Ил Тод байдал сан	Улаанбаатар хот	ТББ	\$ 16,445
14	Инфратест Сургалт Судалгааны Төв	Улаанбаатар хот	ТББ	\$ 4,870
15	Иргэдийн Экологийн Боловсрол сан	Улаанбаатар хот	ТББ	\$ 2,190
16	IRIM сан	Улаанбаатар хот	ТББ	\$ 5,700
17	ЛЕОС-гийн Өвөрхангай аймаг дахь салбар	Өвөрхангай аймаг	ТББ	\$ 3,450
18	Монгол Байгаль Эхийн Аврал Сан	Улаанбаатар хот	ТББ	\$ 5,001
19	Монгол-Японы Шинжлэх Ухаан Хамтын ажиллагаа Дэмжих Холбоо	Улаанбаатар хот	ТББ	\$ 3,580
20	Мэдлэг Чадвар Хандлага	Булган аймаг	ТББ	\$ 5,770
21	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн	Улаанбаатар хот	ТББ	\$ 38,905
22	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн	Улаанбаатар хот	ТББ	\$ 7,840
23	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Өмнөговь аймаг дахь салбар	Өмнөговь аймаг	ТББ	\$ 3,100

24	Нийгмийн Шинэчлэл Сан	Улаанбаатар хот	ТББ	\$	5,020
25	Орон Нутгийн Удирлагын Хөгжлийг Дэмжих сан	Улаанбаатар хот	ТББ	\$	5,150
26	Өнөөгийн Баянхонгор сонин	Баянхонгор аймаг	ТББ	\$	1,690
27	Сод Номун Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	4,470
28	Социологийн Боловсрол Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	4,860
29	Технологи Инновацийн Залуу Судлаачдын Нийгэмлэг	Улаанбаатар хот	ТББ	\$	4,750
30	Тэнгэрийн Таалал сан	Улаанбаатар хот	ТББ	\$	4,780
31	Үндэсний Соёмбо Хөдөлгөөн	Улаанбаатар хот	ТББ	\$	22,600
32	Филантропи Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	25,190
33	Хил Хязгааргүй Алхам	Улаанбаатар хот	ТББ	\$	4,800
34	Хонгор Нутгийн Дуудлага	Баянхонгор аймаг	ТББ	\$	4,830
35	Хөвсгөл Далайн Эзэд	Хөвсгөл аймаг	ТББ	\$	4,375
36	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгуулагуудын Үндэсний Холбооны Өмнөговь аймаг дахь салбар	Өмнөговь аймаг	ТББ	\$	4,390
37	Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн Өмнөгөвь аймаг дахь салбар	Өмнөговь аймаг	ТББ	\$	4,360
38	Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн Дархан Уул аймаг дахь салбар	Дархан-Уул аймаг	ТББ	\$	3,660
39	Хүний Эрх Хөгжил Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	8,350
40	Хүний Эрхийг Хамгаалах Сан	Улаанбаатар хот	ТББ	\$	4,290
41	Хүнс Эвсэл	Улаанбаатар хот	ТББ	\$	4,630
42	Хууль Хүний Эрх Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	21,300
43	Хууль Хүний Эрх Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	4,270
44	Хуульч Эмэгтэйчүүдийн Холбооны Завхан аймаг дахь салбар	Завхан аймаг	ТББ	\$	1,300
45	Хүүхдэд Экологийн Боловсрол Олгох Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	5,025
46	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв	Улаанбаатар хот	ТББ	\$	540
47	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв	Улаанбаатар хот	ТББ		5,000

48	Эмэгтэй Удирдагч Сан	Улаанбаатар хот	ТББ	\$	4,860
49	Эрүүл Урт Наслалт	Улаанбаатар хот	ТББ	\$	5,060
50	Мэдээлэл, Харилцаа Холбоо, Технологийн Газар	Улаанбаатар хот	Төрийн	\$	6,920
51	Хууль зүй Дотоод Хэргийн Яам	Улаанбаатар хот	Төрийн	\$	41,200
52	Орхон аймгийн Номын Сан	Орхон аймаг	Төрийн	\$	5,820
53	Нийтийн Номын Сан	Баянхонгор аймаг	Төрийн	\$	6,000
54	Хүүхэд Залуучуудын номын сан	Улаанбаатар хот	Төрийн	\$	2,597
<b>Байгууллагад олгосон нийт тэтгэлгийн дүн</b>					<b>\$ 491,084</b>
55	Төлсөн Авснаа Нийтэл	Улаанбаатар хот	Эвсэл	\$	12,154
56	Д.Цэрэнжав	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,488
57	Г.Батжил	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	260
58	Л.Цэрэнханд	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	260
59	Г.Долгормаа	Сүхбаатар аймаг	Хувь хүн	\$	361
60	Н.Нарантуяа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	260
61	Ц.Хун	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,984
62	Б.Алтансарнай	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,443
63	Б.Онон	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,533
64	Т.Амгалан	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,533
65	Р.Банди	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,079
66	Н.Нарантуяа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,079
67	С.Болд	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
68	Б.Дэлгэрсайхан	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
69	Ж.Батэрдэнэ	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
70	Б.Эрдэнэбадрах	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
71	Д.Түмэнбаяр	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
72	Э.Энх Амгалан	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549

73	Г.Ганбаясах	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
74	Т.Цогзолмаа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
75	Э.Хишигбаяр	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
76	Ө.Эрдэнэчимэг	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,549
77	Ц.Ганболд	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,325
78	А.Батпүрэв	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,708
79	Ч.Дэлгэрмаа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,708
80	Б.Болдбаатар	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,708
81	Ю.Отгонжаргал	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	2,708
82	Н.Нарантуяа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,654
83	Г.Батжил	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,533
84	Г.Долгормаа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,533
85	Ж.Гүндэгмаа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,673
86	Н.Мандаа	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,673
87	Б.Сувд	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,673
88	Д.Дондог	Улаанбаатар хот	Хувь хүн	\$	1,782
<b>Хувь хүмүүст олгосон тэтгэлгийн нийт дүн</b>				<b>\$</b>	<b>68,602</b>
<b>Нийт дүн</b>				<b>\$</b>	<b>559,686</b>

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

### **Үдирдах зөвлөлийн дарга:**

П.Цэнгүүн ptsenguun@altantaria.mn

### **Үдирдах зөвлөлийн гишүүд:**

Д.Ганбат	ganbat@academy.org.mn
Л.Төр-Од	turod@khasbank.mn
Н.Туяа	tuya05@yahoo.com
Х.Тэмүүжин	temuijin@lawyer.com
Г.Уранцоож	chrd@mongolnet.mn
С.Цэрэндорж	s.tserendorj@nhrc-mn.org

### **Гүйцэтгэх захирал:**

П.Эрдэнэжаргал jargal@forum.mn

### **Ажилтнууд:**

Ж.Баярцэцэг	Засаглалын асуудал хариуцсан менежер	bayar@forum.mn
П.Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	
Н.Дорждарь	Эдийн засгийн асуудал хариуцсан менежер	dorjdari@forum.mn
Б.Мөнхсоёл	Эдийн засаг, Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан менежер	soyoloo@forum.mn
А.Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын асуудал хариуцсан менежер	gerelmaa@forum.mn
Д.Энхцэцэг	Засаглалын асуудал хариуцсан менежер	enkhee@forum.mn
Д.Долгорсүрэн	Хөтөлбөрийн туслах ажилтан	fassistant@forum.mn
О.Оюунсаруул	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
Б.Хажидмаа	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
Д.Балжид	Мэдээллийн төвийн менежер	baljid@forum.mn
Д.Баярмаа	Мэдээлийн төвийн туслах ажилтан	dircassist@forum.mn
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	gantuya@forum.mn
Д.Жавхлан	Санхүү, захиргааны захирал	javkhlan@forum.mn
Д.Аюуш	Нягтлан бодогч, тэтгэлэгийн менежер	ayush@forum.mn
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	ulzii@forum.mn
Т.Отгонбаяр	Захирлын туслах	reception@forum.mn
Б.Баатар	Жолооч	baatar@forum.mn
Г.Цэдэвхүү	Жолооч	tsedev@forum.mn
Ц.Саруул	Жолооч	saruul@forum.mn
Ш.Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	ganaa@forum.mn
<b>Нийтлэг Имэйль:</b>	<b>osf@forum.mn</b>	

## Товчилсон үгс

АМТХ - Ашигт малтмалын тухай хууль  
БСШУЯ - Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам  
ГҮҮКТ - Геологи, Уул Уурхай Кадастрын Газар  
ДЭЗФ - Дэлхийн Эдийн Засгийн Форум  
ДЭЗЭЧИ - Дэлхийн Эдийн Засгийн Эрх Чөлөө Индекс  
ЗГХЭГ - Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар  
ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  
МУБИС - Монгол Улсын Боловсролын Их Сургууль  
МУИС - Монгол Улсын Их Сургууль  
МООНРТ - Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз  
МЭЗЭЧТ - Монголын Эдийн Засгийн Эрх Чөлөөний Тойм  
ННФ - Нээлттэй Нийгэм Форум  
НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага  
СЕХ - Сонгуулийн Ерөнхий Хороо  
ТТБ - Төрийн бус байгууллага  
УИХ - Улсын Их Хурал  
ФИ - Фрейзер Институт  
ЭМШУИС - Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль